

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага

ШУТИС-ийн Тэсэлгээний сургалт, судалгааны төв

# ГАРЫН АВЛАГА

(Үйлдвэрийн нөхцөлд)

Тэсэлгээний сургалтанд хамрагсадад  
зориулав.

Улаанбаатар хот  
2023 он

**ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**ТЭСЭЛГЭЭНИЙ СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ТӨВ**

Редактор: Монгол улсын зөвлөх инженер Л.ДАВААЦЭДЭВ  
Эмхэтгэсэн: Магистр Г.АМАРТҮВШИН  
Магистр А.НЯМТУЛГА

Энэхүү гарын авлагыг тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцах эрхийн сургалтанд хамрагдах ажилтнуудад зориулав. Гарын авлагад Монгол улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тэсэлгээний ажил, үйлчилгээ эрхлэгч байгууллагын дагаж мөрдөх хууль, дүрэм, журам, тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн ангиллыг эмхтгэж оруулав.

Улаанбаатар хот

2023 он

## Агуулга

<b>1. ТЭСРЭХ БОДИС БОЛОН ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН АНГИЛАЛ</b> .....	4
Тэсрэх материалын хамтатгах бүлгийн ангилал.....	4
Тэсрэх материалын дэд ангийн ангилал.....	4
Тэсрэх материалыг хэрэглэх нөхцлийн ангилал.....	6
Тэсрэх материалын төрлүүд.....	8
<b>2. МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ЭРГЭЛТИЙГ ЗӨВШӨӨРӨХ, ОЛОН УЛСАД БҮРТГЭЛТЭЙ ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ БОЛОН ТЭДГЭЭРИЙН ҮНДСЭН ТҮҮХИЙ ЭДИЙН ЖАГСААЛТ</b> .....	10
<b>3. “ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬ”-ИАС</b> .....	12
Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл.....	12
Гуравдугаар бүлэг: Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн аюулгүй ажиллагааг хангах.....	13
тавдугаар бүлэг: Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хяналт, хариуцлагын тогтолцоо.....	20
<b>4. ТЭСЭЛГЭЭНИЙ АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ДҮРМИЙН ЗААЛТААС</b> .....	22
Дүрмийн нэр томъёоны тодорхойлолт.....	22
Ерөнхий зүйл.....	23
<b>5. ТЭСЭЛГЭЭНИЙ АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА</b> ..	24
Тэсрэх материалыг турших ерөнхий шаардлага.....	24
Тэсрэх материалыг устгах ерөнхий шаардлага.....	24
Тэсрэх материалыг ачиж буулгах, тээвэрлэх ерөнхий шаардлага.....	25
Тэсэлгээний ажил гүйцэтгэх ерөнхий шаардлага.....	28
Тэсрэх бодисыг үйлдвэрлэх ба хэрэглээнд бэлтгэх үйлдвэр, механикжуулсан цэгийн ашиглалтын аюулгүй ажиллагааны шаардлага.....	33
Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодис бэлтгэх байрны ашиглалтын шаардлага. Техникийн болон технологийн баримт бичгүүд.....	43
Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх тоног төхөөрөмжид тавих шаардлага.....	45
Статик цахилгаанаас хамгаалах аргууд.....	46
Тэсрэх бодисын үйлдвэрт тэсрэх материалыг хадгалах, бүртгэх үйл ажиллагаа.....	48
<b>6. ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН АГУУЛАХ БАЙГУУЛАХ, АШИГЛАХАД ТАВИХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА</b> .....	48
Тэсрэх материалын бүртгэл, тооцоо.....	55
<b>7. ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН АГУУЛАХ, ҮЙЛДВЭРИЙН ХАМГААЛАЛТЫН ЖУРАМ</b> ...	57

## ТЭСРЭХ БОДИС БОЛОН ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН АНГИЛАЛ

“Тэсрэх материал” гэж тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон үйлдвэрийн зориулалттай тэсрэх бодис бэлтгэхээр зориулан бэлтгэсэн хольцуудыг хэлнэ.<sup>1</sup> Тэсрэх материалыг аюулын зэргээр нь дараах байдлаар ангилна.

### Тэсрэх материалын хамтатгах бүлгийн ангилал

Хамтатгах бүлэг (аюулын зэрэг)	Бодис, бүтээгдэхүүн
<b>B</b>	Өдөөгч тэсрэх бодис агуулсан бөгөөд хоёр хүртэл үл хамаарах хамгаалалтын төхөөрөмжтэй бүтээгдэхүүн. Түүнчлэн ердийн детонатор, детонатор агуулсан хэрэгсэл, ба өдөөгч тэсрэх бодис агуулаагүй детонаторууд орно.
<b>C</b>	Шидэх үйлчилгээтэй тэсрэх бодис ба бүтээгдэхүүн (утаагүй дарь)
<b>D</b>	Тэсрэх бодис. Тэсэлгээний хэрэгсэл ба шидэх үйлчилгээтэй цэнэг агуулаагүй тэсрэх бодис бүхий бүтээгдэхүүн. Өдөөгч тэсрэх бодис агуулсан бөгөөд хоёр ба түүнээс дээш тооны үл хамаарах хамгаалалтын төхөөрөмжтэй бүтээгдэхүүн
<b>E</b>	Тэсэлгээний хэрэгсэлгүй тэсрэх бодис агуулсан, гэхдээ шидэх үйлчилгээтэй цэнэг бүхий бүтээгдэхүүн (хялбархан дөл авалцдаг шингэн, гель буюу өөрөө шатдаг шингэнээс бусад)
<b>F</b>	Хоёрдогч тэсэрч дэлбэлэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ба шидэх үйлчилгээтэй цэнэг агуулсан, эсвэл шидэх үйлчилгээтэй цэнэг агуулаагүй бүтээгдэхүүн
<b>G</b>	Пиротехникийн бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүн
<b>N</b>	Мэдрэмтгий чадвар нь онцгой муу тэсрэх бодис агуулсан бүтээгдэхүүн
<b>S</b>	Гадны гэнэтийн үйлдлээс цочрол авч тэсрэх аюул тохиолдоход түүний үйлчилгээг хязгаарлах сав, баглаа боодолтой, хэрэв сав баглаа нь галд өртөж гэмтвэл тэсрэлтийн нөлөө цацалт нь аваар устгах, гал унтраахаар сав баглааны дэргэд хүн ажиллахад саад болохгүйгээр тусгайлан бүтээгдсэн бодис, бүтээгдэхүүн

Тэсрэх материалыг гадны нөлөөлөлд хамгийн мэдрэмтгийгээс нь бага мэдрэмтгий үрүү нь бууруулан англи цагаан толгойн дарааллаар дугаарласан ангилал. Тэсрэх материалыг хадгалах тэвэрлэхэд хамтатгаж болох, болохгүйг тодорхойлно.

### Тэсрэх материалын дэд ангийн ангилал

Дэд анги	Дэд ангийн нэр
<b>1.1</b>	Бөөнөөр тэсрэх аюултай тэсрэх материалууд
<b>1.2</b>	Бөөнөөр тэсрэхгүй, гэхдээ тэсрэлтээр цацалт үүсгэх болон орчны зүйлийг гэмтээх аюултай тэсрэх материалууд
<b>1.3</b>	Бөөнөөр тэсрэхгүй, шатах аюултай тэсрэх материалууд
<b>1.4</b>	Тэвэрлэлтийн явцад гал гарах буюу өдөөсөн тохиолдолд бага зэргийн тэсрэлтийн аюултай тэсрэх материал. Тэсрэлтийн үйлчлэл нь сав баглаагаар хязгаарлагдана. Гадны өдөөх эх үүсвэр сав баглаа дотор огцом тэсрэлт үүсгэхгүй.

<sup>1</sup> Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны дүрэм

<sup>2</sup> “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн Хавсралт 1

Дэд анги	Дэд ангийн нэр
1.5	Бөөнөөр тэсрэх аюултай, гэхдээ мэдрэмтгий чадвар нь маш бага, тээвэрлэлтийн хэвийн нөхцөлд өдөөлт үүсэх ёсгүй буюу шаталтаас тэсрэлтэд шилжихгүй тэсрэх материалууд
1.6	Тохиолдлын өдөөлтөд өртөх магадлал багатай, бөөнөөр тэсрэхгүй, нэн бага мэдрэх чадвартай тэсрэх тэсрэх бодисоор хийсэн бүтээгдэхүүн. 1.6 дэд ангийн бүтээгдэхүүний аюул нь нэг бүтээгдэхүүний тэсрэлтээр хязгаарлагдана.

Тэсрэх материал тэсэрсэн тохиолдолд үүсэх хор хөнөөлөөрөө хамгийн аюултайгаас нь аюул багатай уруу нь бууруулан 1.1-ээс 1.6 хүртэл дугаарласан ангилал.

Тэсрэх материалыг хэрэглээний нөхцлийн шаардлагаар нь дараах байдлаар ангилна.

### Тэсрэх материалыг хэрэглэх нөхцлийн ангилал

Тэсрэх бодисын анги	Тэсрэх бодисын групп	Тэсрэх бодисын төрөл ба хэрэглэх нөхцөл	Ялгах зурвас буюу боодлын өнгө
I	-	Хамгаалалтгүй тэсрэх бодис Зөвхөн газрын гадарга дээр тэсэлгээ хийхэд хэрэглэнэ.	цагаан
II	-	Хамгаалалтгүй тэсрэх бодис Газрын гадарга дээрх болон газрын доорх шатамхай хий, нүүрс (занар)-ний тэсрэмтгий тоосны ялгаралгүй малталтад буюу мөргөцгийг занаржуулж тэсрэмтгий орчин бий болохоос хамгаалсан нөхцөлд тэсэлгээ хийхэд хэрэглэнэ.	улаан
III	-	Хамгаалалттай тэсрэх бодис Тэсрэмтгий нүүрс /занар/-ний тоосны ялгаралгүй, зөвхөн шатамхай хий ялгаруулдаг газрын доорх мөргөцгийн чулуулагт тэсэлгээ хийхэд хэрэглэнэ.	хөх
IV	-	Хамгаалалттай тэсрэх бодис Шатамхай хийн ялгаралгүй, нүүрс (занар)-ний тоосны тэсрэлтийн аюултай далд уурхайн нүүрс, чулуулаг, шатамхай занарын малталтын мөргөцөгт; Шатамхай хийн ялгаралтай, нүүрс хөрсний далд малталтын нүүрсний давхаргаар нэвтэрч буй шатамхай хийн ихэссэн ялгаралгүй мөргөцөгт; Нүүрсний далд уурхайн доргиох тэсэлгээнд тус тус хэрэглэнэ.	шар
V	-	Хамгаалалттай тэсрэх бодис Уулын чулуулгийн шпурт огтлогдсон ан цавын болон малталт дахь хий агаарын холимог шпурын цэнэгтэй шууд харьцахгүй байгаа тохиолдолд, шатамхай хийн ихэссэн ялгаралтай нүүрсний давхаргаар малтсан газрын доорх малталтын нүүрс, чулуулагт тэсэлгээ хийхэд хэрэглэнэ.	шар

<b>VI</b>	-	Хамгаалалттай тэсрэх бодис Уулын чулуулгийн шпурт огтлогдсон ан цавын болон малталт дахь хий агаарын холимог шпурын цэнэгтэй шууд харьцаж байгаа тохиолдолд, шатамхай хийн ихэссэн ялгаралтай нүүрсний давхаргаар малтсан газрын доорх малталтын нүүрс, чулуулагт; Шатамхай хийн ялгаралтай нүүрсний болон холимог босоо (10°-аас их), 20 м-ээс урт малталтын урьдчилан өрөмдсөн цооноггүй, уурхайн ерөнхий даралтаар агааржуулж буй мөргөцөгт тэсэлгээ хийхэд хэрэглэнэ.	<b>шар</b>
<b>VII</b>	-	Хамгаалалттай тэсрэх бодис, V-VI ангийн хамгаалалттай тэсрэх бодисоор хийсэн бүтээгдэхүүн Газрын доорх малталтад тусгай төрлийн (ус тоосруулах, нунтаг ингибитор тоосруулах, тааз суулгахад модон бэхэлгээ унагах, нүүрс буулгах малталтын гацаа гаргах, овор бутлах) тэсэлгээний ажил явуулах үед шатамхай хий болон нүүрсний тоосны тэсрэлтийн аюултай агуулга үүсэж болох мөргөцөгт тэсэлгээ хийхэд хэрэглэнэ.	<b>шар</b>
<b>Тусгай (C)</b>	-	Хамгаалалтгүй ба хамгаалалттай тэсрэх бодис, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүн Шатамхай хий болон нүүрс (занар)-ний тоосны тэсрэлтийн аюултай агуулга үүсэж болох газрын доорх малталтын мөргөцгөөс бусад газарт тусгай зориулалтын тэсэлгээний ажилд хэрэглэнэ.	-
	1	Газрын гадарга дээр тэсэлгээний ажил хийхэд хэрэглэнэ. Металл боловсруулах; цооногийн болон төвлөрсөн цэнэгийг өдөөх; доголын налуу үүсгэх хүрээний тэсэлгээ, хөлдүүсний тэсэлгээ, овор хэтэрсэн чулуулгийн тэсэлгээ, чичирхийллийн хайгуулын цооногийн тэсэлгээ, ойн түймрийн хамгаалах зурвасны тэсэлгээ, бусад тусгай зориулалтын тэсэлгээний ажил	<b>цагаан</b>
	2	Хий, тоосны аюулгүй далд уурхайд; сульфидын хүдэрт овор ихтэй уулын цулыг бутлах, хүрээ үүсгэх тэсэлгээ болон бусад тусгай зориулалтын тэсэлгээний ажилд хэрэглэнэ.	<b>улаан</b>
	3	Хайгуулын, газрын тосны, хийн цооногт цөмлөх буудлагын тэсэлгээ хийхэд хэрэглэнэ.	<b>хар</b>
	4	Хүхрийн тоос, устөрөгч, хүнд нүүрс устөрөгчийн уурын тэсрэлтийн аюултай хүхрийн, газрын тосны болон бусад далд уурхайд тэсэлгээ хийхэд хэрэглэнэ.	<b>ногоон</b>

## Тэсрэх материалын төрлүүд

“Тэсрэх бодис” гэж анфо (энгийн найрлагатай, хүчитгэсэн) тэсрэх бодис, эмульсийн тэсрэх бодис болон аммонит, динамит, тротил, бүүстер (booster), цочир дамжуулах шижим зэргийг хэлнэ.<sup>5</sup>

“Тэсэлгээний хэрэгсэл” гэж тэсрэх бодисын цэнэгт тэсрэлтийн өдөөлт өгөх зориулалттай тэсрэх бодис, өдөөх хэрэгслийг хэлнэ.<sup>6</sup>

Тэсрэх материалыг тэсрэлтэд мэдрэмтгий байдал болон тэсрэлтийн хүчний шинж чанараар нь дараах байдлаар ангилдаг.

- Тэслүүр
- Нунтаглах чадвар өндөртэй хүчтэй тэсрэх бодисууд
- Сул хүчтэй тэсрэх бодисууд

### Тэслүүр:

- Ердийн тэслүүр
- Цахилгаан тэслүүр
  - Агшны
  - Удаашруулалттай
  - Хамгаалалттай
- Цахилгаан бус тэслүүр
  - Цооног, шпурын систем
  - Гадаргуугийн холбогчтой систем
  - Цооногийн болон гадаргуугийн холбогчтой хосолсон систем
- Цахим тэслүүр
- Дээрх төрлийн тэслүүрүүд агуулсан тэсэлгээний өдөөх хэрэгслүүд

Тэслүүр болон бүтцэд нь тэслүүр агуулагдсан тэсэлгээний хэрэгсэл нь тэсэлгээний өдөөх хэрэгсэлд орно.

### Нунтаглах чадвар өндөртэй хүчтэй тэсрэх бодис:

Анхдагч өдөөгч тэсрэх бодисууд:

- Тэсрэмтгий мөнгөн ус  $Hg(ONC)_2$  тэсрэмтгий хүчлийн давс, цагаан ба саарал өнгөтэй, 4.4 г/см<sup>3</sup> нягттай жижиг талст нунтаг
- Тугалганы азид  $Pb(N_3)_2$  Азотот ус төрөгчийн хүчлийн тугалганы давс, 4.8 г/см<sup>3</sup> нягттай жижиг талст нунтаг
- Тенерес  $C_6H(NO_2)_3(OPb)_2$  алтан шаравтар талст нунтаг, 3.2 г/см<sup>3</sup> нягттай;

Хоёрдогч өдөөгч тэсрэх бодисууд:

- Тетрил  $C_6H_2(NO_2)_3N(CH)_3NO_2$  – бүдэг шаргал өнгөтэй, жижиг талст нунтаг
- ТЭН  $C_5H_8(ONO_2)_3$  - цагаан өнгөтэй 1.75-1.77 г/см<sup>3</sup> нягттай кристал нунтаг (PETN)
- Гексоген  $C_3H_6N_6O_6$  - цагаан өнгөтэй 1.7 г/см<sup>3</sup> нягттай кристал нунтаг (RDX)
- Октоген  $V_4H_8N_8O_8$  - цагаан өнгөтэй 1.7 г/см<sup>3</sup> нягттай кристал нунтаг (HMX);

Тэслүүрт мэдрэмтгий хүчтэй тэсрэх бодисууд:

- Нитроглицерин  $C_3H_5(ONO_2)_3$  - өнгөгүй, тунгалаг, хүнд шингэн, 1.6 г/см<sup>3</sup> нягттай. Шингэн нитроглицерин +13.2<sup>0</sup>C -т царцана
- Нитроглицоль  $C_2H_4(ONO_2)_2$  – өнгөгүй хүнд шингэн, 1.5 г/см<sup>3</sup> нягттай

<sup>5</sup> Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны дүрэм

<sup>6</sup> Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны дүрэм

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага

- Тротил (тринитротолуол)  $C_6H_2(NO_2)_3CH_3$  – өнгөлөг ба бүдэг шар өнгөтэй ромбо хэлбэрийн талст (TNT)
- Динамит – нитроглицерин, аммиакийн шүүний (эсвэл кали, натрийн) нэгдэл болон сийрэгжүүлэгч (модны гурил), тогтворжуулагч (сод, шохой) нэмэгдэл зэргийн хольц, 1.4-1.5 г/см<sup>3</sup> нягттай
- Аммонит – аммиакийн шүү, тротилын хайлуулсан нэгдэл
- Эмульсийн тэсрэх бодис – 60 мм хүртэл бага диаметртай боодлоор савласан (аммиакийн шүүний усан уусмал болон эмульсжүүлэгч тосон уусмалаас үүссэн эмульсийг химийн хийжүүлэгчээр, эсвэл микро шилэн бөмбөлгөөр мэдрэгжүүлсэн)
- Цочир дамжуулах шижим, бүүстер зэрэг тэслүүрт мэдрэмтгий тэсрэх бодисын орцтой тэсэлгээний өдөөх хэрэгслүүд;

Тэслүүрт мэдрэмтгий бус хүчтэй тэсрэх бодисууд:

- Гранулит тэсрэх бодис – аммиакийн шүүний хатаасан мөхлөгт минералын тосыг шингээж тротил, хөнгөн цагааны нунтаг эсвэл өөр шатах нэмэгдлийн механик хольц
- АНФО тэсрэх бодис – аммикийн шүүнд дизель түлш шингээсэн энгийн найрлагатай болон хөнгөн цагааны нунтаг өөр шатах нэмэгдлийн механик хольц
- Эмульсийн тэсрэх бодис – 60 мм-ээс дээш диаметртай боодлоор савласан болон задгай (аммиакийн шүүний усан уусмал болон эмульсжүүлэгч тосон уусмалаас үүссэн эмульсийг химийн хийжүүлэгчээр, эсвэл микро шилэн бөмбөлгөөр мэдрэгжүүлсэн);
- Бусад тэслүүрт мэдрэмтгий тэсрэх бодисууд.

Тэслүүрт мэдрэмтгий тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тэслүүрээр өдөөж тэсэлнэ. Тэслүүрт мэдрэмтгий бус тэсрэх бодисыг бүүстэр болон түүнтэй адилтгах өдөөх хэрэгслээр өдөөж тэсэлнэ.

### **Сул хүчтэй тэсрэх бодис**

Тэсрэлтээс үүссэн хийн бүтээгдэхүүнээр нь чулуулгийн ан цавыг нэмэгдүүлж задлах зориулалтаар ашигладаг (газрын тосны цооногийн шингэн хагалгааны цэнэг гэх мэт) тэсрэх бодис.



Засгийн газрын 2023 оны 05 дугаар  
сарын 24-ний өдрийн 202 дугаар  
тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ЭРГЭЛТИЙГ ЗӨВШӨӨРӨХ, ОЛОН УЛСАД  
БҮРТГЭЛТЭЙ ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ БОЛОН  
ТЭДГЭЭРИЙН ҮНДСЭН ТҮҮХИЙ ЭДИЙН ЖАГСААЛТ**

№	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн төрөл	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн төрлийн хэлбэрүүд	БТКУС код
А	Б	В	Г
<b>Нэг. Тэсэлгээний хэрэгсэл</b>			
1.	Цахилгаан тэслүүр	агшны	3603
		удаашруулалттай	
		хамгаалалттай	
		газрын тос, хийн цооногийн	
2.	Галын бялт тэслүүр	агшны хонгиотой	3603
3.	Цахилгаан бус тэслүүр	цахилгаан бус тэслүүрийн систем угсрах бэлдэц	3603
4.	Цахилгаан бус тэслүүрийн систем	цооног, шпурын	3603
		гадаргуугийн холбогч блоктой	
		цооногийн болон гадаргуугийн холбогч блоктой хосолсон	
5.	Цочир дамжуулах шижмийн гадаргуугийн удаашруулагч систем	цочир дамжуулах шижмээр холбох	3603
		цохилтын долгион дамжуулах гуурстай холбогч блоктой	
6.	Цахим тэслүүр	утастай	3603
		утасгүй	
7.	Цохилтын долгион дамжуулах гуурс	цахилгаан бус тэслүүрийн систем угсрах бэлдэц	3603
		тэсэлгээний холболтын шугамын, тэслүүргүй	
		тэсэлгээний холболтын шугамын, тэслүүртэй	
8.	Гал дамжуулах шижим		3603
9.	Гал дамжуулах шижмийн асаагуур	галын	3603
		цахилгааны	
<b>Хоёр. Тэсрэх бодис</b>			
10.	Цэнэг өдөөх тэсрэх бодисын хэрэгсэл бэлтгэх өндөр хүчин чадалтай тэсрэх бодис	RDX	3602
		TNT	3602
		PETN	3602

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага

		PETN, TNT холимог	3602
11.	Өдөөгч тэсрэх бодис	цооног, шпурын	3602
		чиглэсэн үйлчлэлтэй гадаргуугийн	
12.	Перфорацийн цэнэг	газрын тос, хийн цооногийн	3602
13.	Пресплитийн цэнэг	газрын тос, хийн цооногийн	3602
14.	Аммонит тэсрэх бодис	боодолтой, хамгаалалттай	3602
15.	Динамит тэсрэх бодис	бортоготой, чичирхийллийн	3602
16.	Гранулит тэсрэх бодис	мөхлөгтэй, задгай	3602
17.	Анфо тэсрэх бодис	энгийн найрлагатай, савлагаатай	3602
		нэмэлт хольцтой, савлагаатай	
		энгийн найрлагатай, задгай	
		хүнд анфо савлагаатай	
18.	Эмульсийн тэсрэх бодис	савлагаатай, тэслүүрт мэдрэмтгий	3602
		савлагаатай тэслүүрт, мэдрэмтгий бус	
		задгай	
		анфогийн хольцтой задгай	
19	Цочир дамжуулах шижим	гадаргуугийн холболтын бага хүчин чадлын	3602
		өндөр хүчин чадлын	
		газрын тос, хийн цооногийн	
<b>Гурав. Үндсэн түүхий эд</b>			
20.	Аммиакийн шүү	аммиакийн шүү цэвэр	3102.30
		аммиакийн шүү сүвэрхэг	3102-30
21	Аммиакийн шүүний эмульс	задгай, мэдрэгжүүлээгүй	дотоодод зөвшөөрөгдөх

## “ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬ”-ИАС

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь үйлдвэрлэлийн зориулалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих, тэдгээрийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангах, хууль бус хэрэглээг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль тогтоомж

2.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай, Ашигт малтмалын тухай, Зөвшөөрлийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

[/Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

#### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь цэргийнхээс бусад зориулалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих хүрээнд үйлчилнэ.

#### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“тэсэрч дэлбэрэх бодис” гэж тэсэлгээний хэрэгсэл, гадны үйлчлэлийн нөлөөгөөр агшин зуурын хугацаанд химийн урвалд орж, өндөр даралт үүсгэн дулаан ялгаруулах химийн нэгдэл буюу механик хольцыг;

4.1.2 “тэсэлгээний хэрэгсэл” гэж тэсэрч дэлбэрэх бодисын тэсрэлтийг үүсгэх зориулалттай цэнэг агуулсан өдөөгч хэрэгслийг;

4.1.3 “пиротехникийн хэрэгсэл” гэж хурц гэрэл гэгээ цацруулдаг буюу чанга дуу чимээ үүсгэдэг баяр ёслол, үзвэр, цэнгээний зориулалтаар ашиглагдах хэрэгслийг;

4.1.4 “тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлт” гэж тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах, тэсэлгээний ажил явуулах үйл ажиллагааг;

[/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

4.1.5 “тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг устгах” гэж шатаах, тэслэх, уусгах арга технологийг ашиглан хор хөнөөлгүй болгохыг;

4.1.6 “тэсэлгээний ажил явуулах” гэж тэсэлгээний ажлыг удирдах, тэсэлгээ хийх, тэсрэх материалыг бүртгэх үйл ажиллагааг гүйцэтгэхийг;

[/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

4.1.7. “мэдээллийн нэгдсэн сан” гэж төрийн захиргааны байгууллага болон хуулийн этгээдээс энэ хуульд заасны дагуу ирүүлсэн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн талаарх мэдээ мэдээлэл, тайлангийн нэгтгэлийг;

4.1.9 “Мэргэжлийн зөвлөл” гэж тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих чиг үүрэгтэй төрийн байгууллага болон мэргэжлийн

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага холбоо, судалгаа, шинжилгээний байгууллагын төлөөллийг оролцуулсан зөвлөлийг;

4.1.10. “шинжээч” гэж бие даан мэргэжлийн дүгнэлт гаргах эрх бүхий тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн чиглэлээр мэргэшсэн болон зөвлөх зэрэгтэй инженерийг.

[/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ: ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ**

### **9 дүгээр зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, хадгалалтын аюулгүйн бүс**

9.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах нь аюулгүйн бүстэй байна.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан аюулгүйн бүс, түүний дэглэмийг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд заасны дагуу тогтооно.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

### **10 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулахын аюулгүй ажиллагаа**

10.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах дахь аюулгүй ажиллагааг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмээр тогтооно.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

10.2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулах нь байнгын болон түр гэсэн төрөлтэй байна. Агуулахын төрөл тус бүрд тавих шаардлага, агуулах хооронд эргэлт хийх журмыг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмээр тогтооно.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

### **11 дүгээр зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэхэд тавих шаардлага**

11.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх хуулийн этгээдэд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т зааснаас гадна дараах шаардлага тавина:

[/Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

11.1.1. өөрийн эзэмшлийн газар дээр байгуулсан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны техникийн шаардлага хангасан зориулалтын барилга байгууламж, байнгын агуулах, тоног төхөөрөмж, лаборатори, туршилтын талбайтай байх;

[/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

11.1.2.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн аюулгүй ажиллагааны шаардлага хангасан ачиж буулгах тусгай зориулалтын тоног төхөөрөмж, дотоодын тээврийн хэрэгсэлтэй байх;

[/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага  
11.1.3.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн чанарын үзүүлэлт нь үндэсний болон олон улсын стандартын шаардлага хангасан байх;

11.1.4.шинэ төрлийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэхэд Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу туршилт хийлгэн, шинжээчийн дүгнэлт гаргуулж, стандартаа баталгаажуулсан байх;

[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

11.1.5.мэргэжлийн ажиллах хүчнээр хангагдсан байх;

11.1.6.цагдаа, тагнуулын болон онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг авсан байх;

[/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

11.1.7.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэхэд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн байх;

[/Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

11.1.8.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн байр, агуулахад гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байх.

11.1.9.хуулийн этгээдийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эзэмшдэг байх.

[/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

11.2.Үйлдвэрлэсэн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл сери /цуврал/ дугаар бүхий сав, баглаа боодолтой байх ба сери /цуврал/ дугаарыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

11.3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн сав, баглаа боодлын гадна талд үйлдвэрийн нэр, үйлдвэрлэсэн болон хадгалах баталгаат хугацаа, тэсэрч дэлбэрэх аюултайг анхааруулсан таних тэмдэгтэй байна.

11.4.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, пиротехникийн хэрэгслийн үйлдвэрийг шинээр байгуулж, ашиглалтад оруулахад шинжээчийн болон Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг гаргуулсан байна.

[/Энэ хэсэгт 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

11.5.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд хувь нийлүүлсэн хөрөнгөд гарсан өөрчлөлтийн талаарх мэдээллээ хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш ажлын таван өдрийн дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

11.6.Энэ хуулийн 11.1.5-д заасан мэргэжлийн ажиллах хүчинд тавих шаардлагыг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмээр тогтооно.

11.7.Энэ хуулийн 11.1.6-д заасан байгууллага хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 20 өдөрт багтаан энэ хууль болон Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмээр тогтоосон тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэхэд тавих шаардлагыг хангасан эсэх талаар саналаа гаргана.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага  
11.8.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд орсон өөрчлөлт энэ хуулийн 11.1.9-д заасан шаардлагыг хангаагүй нь тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

## **12 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлоход тавих шаардлага**

12.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох хуулийн этгээдэд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т зааснаас гадна дараах шаардлага тавина:

[/Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

12.1.1. өөрийн эзэмшлийн газар дээр байгуулсан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байнгын агуулах, ачиж буулгах зориулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлтэй байх;

[/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн](#)

12.1.2. цагдаагийн болон тагнуулын төв байгууллага, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг авсан байх.

[/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

12.1.3. мэргэжлийн ажиллах хүчнээр хангагдсан байх.

[/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

12.2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь тэдгээрийн үндсэн түүхий эдийг импортлох эрхтэй.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

12.3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл экспортлох хуулийн этгээдэд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т зааснаас гадна дараах шаардлага тавина:

[/Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

12.3.1.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хуулбар;

12.3.2.экспортлох бүтээгдэхүүний стандарт, техникийн шаардлага хангасан байдлын талаарх мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын тодорхойлолт, экспортлох тоо хэмжээ;

12.3.3.худалдан авагчтай урьдчилан байгуулсан гэрээ, иргэний зориулалтын батламж, тээвэрлэлтийн нөхцөлийг тусгасан баримт бичиг;

12.3.4.цагдаагийн болон тагнуулын төв байгууллага, Зэвсэгт хүчний жанжин штабын санал авсан байх ба санал өгөх хугацааг ажлын 20 өдрийн дотор шийдвэрлэж байх.

[/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

12.4.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэдгээрийн үндсэн түүхий эдийг импортлох тоо хэмжээг заасан зөвшөөрлийг геологи, уул уурхайн асуудал

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухай бүр олгоно.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

12.5.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 12.4-т заасны дагуу олгосон зөвшөөрлийн талаарх мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

12.6. Улсын хилээр нэвтрүүлж байгаа тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэдгээрийн үндсэн түүхий эдийг гаалийн байгууллага бүртгэж, энэ хуулийн 22.1-д заасан мэдээллийн нэгдсэн санд тухай бүр хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

### **13 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл худалдахад тавих шаардлага**

13.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөлтэй этгээд тэдгээрийг зөвхөн энэ хуулийн 15.1, 16.1-д заасан хуулийн этгээдэд худалдана.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

13.4.Хуулийн этгээд нь хэрэгцээнээс илүүдэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг худалдан авах эрх бүхий байгууллагад хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр худалдаж болно.

[/Энэ хэсэгт "мэргэжлийн хяналтын төв" гэснийг "хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий" гэж 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

### **14 дүгээр зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтэд тавих шаардлага**

14.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зөвшөөрөгдсөн чиглэлийн дагуу тээврийн болон аюултай ачааны стандартыг баримтлан тусгай тоногдсон тээврийн хэрэгслээр аюулгүй байдлыг хангаж, харуул хамгаалалттай тээвэрлэх бөгөөд тээврийн хэрэгслийн зөвшөөрөл, тээвэрлэлтийн маршрутыг цагдаагийн байгууллага олгож, харуул хамгаалалтыг дотоодын цэрэг гүйцэтгэж, аюулгүй байдалд хяналт тавина.

[/2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

14.2.Тэсэрч дэлбэрэх бодисыг тэсэлгээний хэрэгслийн хамт тээвэрлэхийг хориглоно.

14.3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн явцад гарч болзошгүй эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх зааварчилгааг тээврийн хэрэгслийн жолооч болон дагалдан яваа хүн бүрд танилцуулж, аюулгүй байдлыг хангасан байна.

14.4.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хот, тосгон, бусад суурин газраар тээвэрлэхдээ аюултай ачаа тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагааны техникийн



Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага шаардлагыг хангасан байна.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

14.5. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг аюулгүй ажиллагааны шаардлага хангасан зориулалтын талбайд ачиж, буулгана.

14.6. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг төмөр замаар тээвэрлэхдээ төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тагнуулын төв байгууллагын хамтран баталсан Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журмыг баримтална.

14.7. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны журмыг цагдаагийн төв байгууллага геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

[/Энэ хэсэгт "мэргэжлийн хяналтын" гэснийг "геологи, үүл үүрхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны" гэж 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

14.8. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тоо хэмжээг тогтоосон тээвэрлэх хуудсыг тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны бэлэн байдал, даацыг харгалзан хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага олгоно.

[/Энэ хэсэгт "мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны" гэснийг "хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий" гэж 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

14.9. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үеийн харуул хамгаалалтын зардлыг тухайн хуулийн этгээд хариуцна.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

## **15 дугаар зүйл. Тэсэлгээний ажил явуулахад тавих шаардлага**

15.1. Тэсэлгээний ажлыг Монгол Улсын хуулийн этгээд гүйцэтгэнэ.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

15.2. Тэсэлгээний ажил явуулах хуулийн этгээдэд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т зааснаас гадна дараах шаардлага тавина:

[/Энэ хэсэгт 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

15.2.1. мэргэжлийн ажиллах хүчинтэй байх;

15.2.2. цагдаагийн болон тагнуулын төв байгууллагын саналыг авсан байх;

[/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

15.2.3. тэсэлгээний ажил явуулах зориулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлтэй байх.



Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага  
[/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн  
найруулсан./](#)

15.3. Тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас олгосон хяналтын хуудсыг үндэслэн үйл ажиллагаа явуулах бөгөөд тэсэлгээний ажлын гүйцэтгэлийн тайланг хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт  
оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт  
оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн  
найруулсан./](#)

15.4. Энэ хуулийн 15.2.2-т заасан байгууллага хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан энэ хууль болон Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмээр тогтоосон тэсэлгээний ажил явуулахад тавих шаардлагыг хангасан эсэх талаар саналаа гаргана.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

15.7. Энэ хуулийн 15.2.1-д заасан мэргэжлийн ажиллах хүчинд тавих шаардлагыг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмээр тогтооно.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

15.8. Тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд түр агуулахыг тэсэлгээний ажил явуулах газарт тухай бүр байгуулна.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

## **18 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах, хамгаалахад тавих шаардлага**

18.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тус тусад нь аюулгүй ажиллагааны шаардлага хангасан зориулалтын агуулахад хадгална.

18.2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн байр, агуулахыг галт зэвсэг эзэмших эрх бүхий гэрээт харуул хамгаалалтын байгууллагаар хамгаалуулна.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт  
оруулсан./](#)

18.3. Хуулийн этгээд нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн орлого, зарлага, үлдэгдлийн бүртгэлийг тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу хөтөлж, улирал тутам тооллого явуулна.

18.4. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл алдагдсан, үрэгдсэн тохиолдолд цагдаагийн болон тагнуулын байгууллагад даруй мэдэгдэх бөгөөд эрэнсурвалжлах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд түүнийг эзэмшигч хуулийн этгээд бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт  
оруулсан./](#)

## **19 дүгээр зүйл. Даатгал**

19.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд оролцож байгаа хуулийн этгээд нь үйл ажиллагааны эрсдэл, иргэний амь нас, эрүүл мэндийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэгт заасны дагуу заавал даатгуулсан байна.

[/Энэ хэсэгт 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт](#)

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага  
[оруулсан./](#)

## **20 дугаар зүйл.Хориглох зүйл**

20.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах зүйлийг хориглоно:

20.1.1. энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй хуулийн этгээдэд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох болон пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл олгох;

[/Энэ заалтад 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

20.1.2. зориулалтын бус газарт тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний болон пиротехникийн хэрэгсэл хадгалах;

[/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

20.1.3. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний болон пиротехникийн хэрэгслийг зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэх;

[/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

20.1.4. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах;

20.1.5. энэ хуулийн 9.1-д заасан аюулгүйн бүсэд хүн, тээврийн хэрэгсэл зөвшөөрөлгүй нэвтрэх, түр буюу байнга суурьших, бүсийн дэглэм зөрчих;

20.1.6. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийг тэсэлгээний ажлын удирдагч болон хамгаалалтын ажилтнаас бусад хүн дагалдан явах;

20.1.7. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хувь хүн олж авах, худалдах, хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах;

20.1.8. хуулийн этгээд нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах, хадгалах, бусдад дамжуулан худалдах, шилжүүлэх.

## **21 дүгээр зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг устгах**

21.1. Чанарын шаардлага хангахгүй болсон, ашиглах хугацаа нь дууссан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг шинжээчийн дүгнэлтийг үндэслэн тухайн хуулийн этгээд нь тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд заасан төлөвлөгөөний дагуу геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хяналтын дор устгана.

[/Энэ хэсэгт 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

21.2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг устгасан тухай үйлдсэн нотолгоог энэ хуулийн 22.1-д заасан мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлнэ.

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага  
[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

21.3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй холбоотой гарсан дуудлага, мэдээлэл болон зөрчил, аюул илэрсэн тохиолдолд онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага аюулгүй болгох арга хэмжээг авна.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

## **ТАВДУГААР БҮЛЭГ: ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО**

### **23 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд тавих хяналт**

23.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд дараах байгууллага хяналт тавина:

23.1.1. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль тогтоомжийн биелэлтэд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага;

[/Энэ заалтад "мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны" гэснийг "геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий" гэж 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

23.1.2. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний болон пиротехникийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэхэд гаалийн байгууллага;

[/Энэ заалтад 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

23.1.3. пиротехникийн хэрэгслийн худалдаа, үзвэрийн зориулалтаар ашиглах үеийн аюулгүй байдалд цагдаа, онцгой байдлын болон хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага;

[/Энэ заалтад "мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны" гэснийг "хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий" гэж 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./](#)

23.1.4.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, хадгалалтын үеийн галын аюулгүй байдал, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

23.2.Хуулийн этгээд нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн зарцуулалт болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тухай хууль тогтоомж, журам, технологийн горимын биелэлтэд дотоод хяналт тавина.

23.3. Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн марк, ангилал, хүчин чадал, ашиглах хугацаа, стандартын чанарын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлохдоо шинжээчийн мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын туслалцааг авна.

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага

[/Энэ хэсэгт 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

23.4. Мэргэжлийн зөвлөлийн гишүүн нь хууль бусаар бусад гишүүндээ нөлөөлөхийг хориглоно.

23.5. Мэргэжлийн зөвлөлийн гишүүн нь төрийн байгууллагыг төлөөлөн албан үүргээ хэрэгжүүлэх үед хувийн ашиг сонирхлыг нийтийн ашиг сонирхлоос дээгүүр тавихгүй.

23.6. Шинжээч нь гаргасан дүгнэлтээ Мэргэжлийн зөвлөлийн өмнө бүрэн хариуцна. Шинжээч нь санаатайгаар үндэслэлгүй дүгнэлт гаргасан бол Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийн дагуу түүний мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэргийг цуцлуулахаар холбогдох байгууллагад хандана.

#### **24 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

24.1. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

[/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

24.2. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

## **ТЭСЭЛГЭЭНИЙ АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ДҮРМИЙН ЗААЛТААС**

### **ДҮРМИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

1. **“Тэсрэх материал”** гэж тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон үйлдвэрийн зориулалттай тэсрэх бодис бэлтгэхээр зориулан бэлтгэсэн хольцуудыг;
2. **“Тэсрэх бодис”** гэж анфо (энгийн найрлагатай, хүчитгэсэн) тэсрэх бодис, эмульсын тэсрэх бодис болон аммонит, динамит, тротил, бүүстер (booster), цочир дамжуулах шижим зэргийг;
3. **Тэсэлгээний хэрэгсэл** гэж тэсрэх бодисын цэнэгт тэсрэлтийн өдөөлт өгөх зориулалттай тэсрэх бодис, өдөөх хэрэгслийг;
4. **“Өдөөх хэрэгсэл”** гэж тэсрэх бодисын цэнэгт тэсрэлтийн өдөөлт өгөх зориулалттай тэслүүр бүхий хэрэгслийг;
5. **“Тэслүүр”** гэж тэсрэлт үүсгэх зориулалттай өдөөгч цэнэг агуулсан хэрэгслийг; Тэслүүр нь ердийн, цахилгаан, цахилгааны бус, электрон зэрэг төрлүүдээс бүрдэнэ.
6. **“Галлагч”** гэж камер, цооног, шпурын цэнэгт тэсрэлт үүсгэх зориулалттай тэслүүр болон цочир дамжуулах шижимтэй угсарсан бүүстер ба тэсрэлтийн мэдрэмж, нунтаглах чадвар өндөртэй боодолтой тэсрэх бодисыг;
7. **“Үндсэн хольц”** гэж тэсрэх бодисын найрлагад ордог аммиакийн шүү, дизель түлш, эмульс, мэдрэгжүүлэгч зэрэг хольцуудыг;
8. **“Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис үйлдвэрлэх”** гэж суурин болон явуулын зориулалтын тоног төхөөрөмж ашиглан үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодисын найрлагад ордог үндсэн хольцуудыг ашиглаж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг;
9. **“Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис бэлтгэх”** гэж суурин болон явуулын зориулалтын тоног төхөөрөмж ашиглан үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодисын найрлагад ордог үндсэн хольц, түүхий эдийн сав баглаа боодлыг задлах, нунтаглах тэдгээрийг хольж, дангаар нь болон тэсрэх бодисуудыг хооронд нь нэгтгэн бэлтгэхийг;
10. **“Тэсрэх материалтай харьцах”** гэж зохион бүтээх, турших, бэлтгэх, үйлдвэрлэх, хадгалах, ачиж буулгах, тээвэрлэх, ашиглах, устгах зэрэг тэсрэх материалтай шууд болон түүний орчинтой харьцаж гүйцэтгэх үйл ажиллагааг;
11. **“Тэсэлгээний ажил эрхлэх эрх бүхий байгууллага”** гэж Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 11, 12, 13, 15, 16, 4.1.8 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийг;
12. **“Тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч”** гэж тэсэлгээний ажлын захиалагч, гүйцэтгэгч бусад хамааралтай этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэгтэй, байгууллагын тушаалаар томилогдсон, тэсэлгээний ажлын удирдагчийн хөтөлбөрөөр суралцаж шалгалт өгч тэсэлгээний ажил удирдах эрхийн “Тэсэлгээний үнэмлэх” эзэмшсэн, тэсэлгээний ажилтай холбоотой асуудлаар шийдвэр гаргах эрх бүхий ажилтныг;
13. **“Тэсэлгээний ажлын удирдагч”** гэж мэргэжил эзэмшихдээ тэсрэх материал, тэсэлгээний ажил сэдвээр суралцсан инженер, бакалавр болон түүнээс дээш зэргийн дипломтой, тэсэлгээний ажлын удирдагчийн хөтөлбөрөөр суралцаж шалгалт өгч тэсэлгээний ажил удирдах эрхийн “Тэсэлгээний үнэмлэх” эзэмшсэн, тэсэлгээний ажил гүйцэтгэх, тэсрэх материал хадгалах, тээвэрлэх, тэсрэх бодис бэлтгэх,

үйлдвэрлэх, харьцах үйл ажиллагааг удирдахаар байгууллагын тушаалаар томилогдсон ажилтныг;

14. **“Тэсэлгээчин”** гэж тэсэлгээчний хөтөлбөрөөр суралцаж, шалгалт өгч “Тэсэлгээчний үнэмлэх” эзэмшсэн, тэсэлгээний ажил гүйцэтгэхээр байгууллагын тушаалаар томилогдсон ажилтныг;

15. **“Тэсрэх материалтай харьцах ажилтан”** гэж тэсрэх материалтай харьцах хөтөлбөрөөр суралцаж, “Тэсрэх материалтай харьцах эрхийн үнэмлэх” эзэмшсэн, тодорхой чиглэлээр тэсрэх материалтай харьцах үйл ажиллагаа гүйцэтгэхээр байгууллагын тушаалаар томилогдсон ажилтныг;

16. **“Мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтан”** гэж мэргэжил эзэмшихдээ тэсрэх материал, тэсэлгээний ажил сэдвээр суралцсан, мэргэшсэн, тэсэлгээний ажил удирдах эрхийн үнэмлэхтэй, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 23.1 дүгээр зүйлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий ажилтныг;

17. **“Ажлын байран дахь тэсрэх материалын тээвэрлэлт”** гэж үйлдвэр, агуулахын талбай доторх дотоодын тээвэрлэлт, тэсрэх материалыг бэлтгэх, үйлдвэрлэлийн байр болон тэсрэх материалын агуулахаас тэсэлгээний ажлын байранд хүргэх технологийн тээвэрлэлтийг;

18. **“Тэсэлгээний ажлын паспорт”** гэж уурхай дээр тогтмол хийгддэг тэсэлгээний ажлын үндсэн үзүүлэлтүүдийг цэнэгийн байрлал болон тэсэлгээний схемийн зураг, бусад шаардлагай тооцооллын хамт харуулсан техникийн баримт бичгийг нэрлэнэ. Паспортын үзүүлэлтүүдийг энэхүү дүрмийн 188, 346 дугаар зүйл, хавсралт 7, 8-д тусгав.

19. **“Тэсэлгээний ажлын төсөл”** гэж уурхай болон бусад газарт байнга бус хийгдэх тэсэлгээний ажлын үндсэн үзүүлэлтүүдийг цэнэгийн байрлал болон тэсэлгээний схемийн зураг, бусад шаардлагай тооцооллын хамт харуулсан техникийн баримт бичгийг нэрлэнэ. Төслийн үзүүлэлтүүдийг энэхүү дүрмийн 187, 341 дүгээр зүйлд тус тус тусгав.

20. **“Зөөврийн үйлдвэр”** гэж тэсрэх бодис үйлдвэрлэх болон тээврийн хэрэгслээр зөөвөрлөх зориулалттай, тусгай зориулалтын бүхээг, чингэлэгт байрлуулсан тоног төхөөрөмж, цэнэглэгч машиныг; (Энэ дэд заалтыг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмсэн)

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Энэхүү дүрмийг үйлдвэрлэлийн зориулалттай тэсэлгээний ажил эрхлэх эрх бүхий байгууллага (цаашид “тэсэлгээний ажил эрхлэх” гэх) заавал дагаж мөрдөх бөгөөд дүрэм нь үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх материалыг бэлтгэх, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх болон ашиглах шаардлагыг тогтооно.

2. Тэсэлгээний ажил эрхлэх эрх бүхий байгууллага нь Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дагуу холбогдох тусгай зөвшөөрлийг авсан байна.

3. Тэсэлгээний ажил эрхлэх эрх бүхий байгууллагын тэсэлгээний ажлыг удирдах, гүйцэтгэх, тэсрэх материалтай харьцах ажилтан нь үнэмлэхтэй байна.

4. Тэсэлгээний ажилд ашиглах тэсрэх материал нь нэр, төрлөөрөө заавал бүртгэлтэй байна.

5. Тэсэлгээний ажилд мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр тухай бүр томилогдсон ажлын хэсэг тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, агуулахын аюулгүй бүсийг тогтоох, тэсэлгээний ажлыг механикжуулах тоног төхөөрөмж, тэсэлгээний багаж, хэмжүүр, аппарат хэрэгслийг туршин хэрэглэх нөхцөлийн талаар дүгнэлт гаргана. Ажлын хэсгийн дүгнэлтээр техникийн нөхцөл,

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага стандартын шаардлага хангахгүй, хэрэглэх боломжгүй нь тогтоогдсон тоног, төхөөрөмж, багаж хэрэгсэл, тэсрэх материалыг ашиглахыг хориглоно. Дүгнэлтийг гаргахад эрх бүхий тэсэлгээний мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын шинжилгээ, сорилт, туршилтын үр дүн, хэрэглэх баталгаат хугацаа нь дууссан тэсрэх материалын талаар дүгнэлтийг ашиглаж болно. (Энэ заалтыг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан)

6. Үйлдвэрлэлийн зориулалттай бүх тэсрэх материал (тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ба цөмлөх-дэлбэлэх аппаратур) нь аюултай байдлын ангилалын I ангид багтана. Тэсрэх материалыг энэхүү дүрмийн хавсралт №1-д заасан хадгалах тээвэрлэхэд мөрдөх хамтатгах бүлэг болон энэхүү дүрмийн хавсралт №2-т заасан мэдрэмтгий байдлын дэд ангид хуваана. Тэсрэх материалыг хэрэглээний нөхцөлөөр нь энэхүү дүрмийн хавсралт №3-т зааснаар ангилна.

7. Тэсрэх материалыг үйлдвэрлэгчийн тогтоосон аюултай байдлын зэрэглэлийн анги, хэрэглэх зааврын дагуу ашиглана.

8. Энэхүү дүрмийн 1-д заасан байгууллагаас мэргэжлийн туслалцаа авч байгаа захиалагч болон тэсэлгээний ажилтай хамааралтай байгууллага, хүмүүс энэхүү дүрмийг заавал мөрдөнө.

## **ТЭСЭЛГЭЭНИЙ АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

### **Тэсрэх материалыг турших ерөнхий шаардлага**

102. Байгууллага нь бүх материалаа хадгалах, ашиглахад тохирч байгааг шалгаж, шаардлагатай тохиолдолд туршина. Үүнд: а) тэсрэх материалын агуулахад материал хүлээж авах шалгалт;

б) тэсрэх материалын гадаад үзлэгээр болон тэсэлгээний ажлын явцад гологдол илэрч, чанарт нь эргэлзсэн тохиолдолд;

в) хэрэв тухайн тэсрэх материалын хадгалалтын хугацааг сунгаж болохыг үйлдвэрлэгчийн ашиглалтын заавар бусад баримт бичигт заасан бол хадгалалтын хугацаа дуусахын өмнө.

103. Тэсрэх материалыг нэг байгууллагын агуулах хооронд шилжүүлэх тохиолдолд туршилт хийхгүй байж болно.

104. Туршилтыг тэсрэх материалын агуулахын лаборатори болон туршилтын талбайд тухайн төрлийн материалыг турших стандарт, техникийн нөхцөл, хэрэглэх арга, аюулгүй ажиллагааны зааврын дагуу гүйцэтгэнэ.

105. Энэхүү дүрмийн хавсралт 5, хавсралт 6-ын дагуу туршилтын үр дүнгийн акт бичиж, туршилтын бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ.

106. Хадгалалтын хугацаа хэтэрсэн тэсрэх материалыг цаашид хэрэглэх эсхүл устгах дүгнэлтийг мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагаар гаргуулна.

107. Шинээр зохион бүтээсэн, туршилтаар үйлдвэрлэсэн тэсрэх материалыг мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагын шинжилгээ, сорилт, туршилтын үр дүн, дүгнэлтийг үндэслэн мэргэжлийн зөвлөлөөс томилогдсон комисс үйлдвэрлэлд нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно.

108. Туршилтад ашигласан тэсрэх материалын зарлагыг бүртгэнэ.

### **Тэсрэх материалыг устгах ерөнхий шаардлага**

116. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон тэсрэх материалыг устгана.

117. Тэсрэх материалыг устгах тухай бүрт тэсрэх материалын нэр төрөл, тоохэмжээ, устгах арга, шалтгааныг тусгасан актыг үйлдэж, геологи, уул уурхайн асуудал

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээллийн санд оруулж, нэг хувийг агуулахын эрхлэгчид үлдээнэ.

118. Тэсрэх материал устгах талбайг төслийн дагуу байгуулж, аюултай бүсийг тодорхойлсон байна.

119. Тэсрэх материалын устгалыг тэсэлгээний ажлын удирдагчийн хяналттайгаар тэсэлгээчин гүйцэтгэнэ.

120. Тэсрэх материалыг тэсэлж устгахдаа сайн чанарын тэсрэх материал ашиглан боодолтой тэсрэх бодис (патрон)-ыг багцаар нь, цочир дамжуулах шижим болон удаашруулах релег тэсрээгүй эд хэсэг цацагдахааргүй боож баглаж тэсэлнэ.

121. Тэслүүр болон тэслүүр агуулсан тэсрэх материалыг шатаахыг хориглоно. Зөвхөн тэсэлж усгана.

122. Тэсрэхгүй болсон тэсрэх материалыг шатааж устгана. Тэсрэх материал шатааж устгах үеийн аюулгүйн зайг тийм хэмжээний тэсрэх бодисыг тэслэх үеийн аюулгүйн зайгаар тооцно.

123. Тэсрэх материалыг зөвхөн хур тунадасгүй үед ашиглалтын зааварт заасан аргачлалын дагуу шатааж устгана.

124. Тэсрэх бодис, гал дамжуулах шижим, цочир дамжуулах шижмийг тус тусад нь нэг түүдгээр 20 кг-аас ихгүйгээр шатаана. Дарийг 30 см-ийн өргөн, 10 см-ийн зузаан, 5 метрээс багагүй зайтай 3-аас илүүгүй зэрэгцээ зурвас болгон асгаж шатаана.

125. Боодолтой тэсрэх бодисыг хоорондоо шүргэлцэхгүйгээр нэг үе өрж шатаана.

126. Боодолтой дарийг түүний техникийн нөхцөлд заасан зааврын дагуу устгана.

127. Тэсрэх материалыг сав, баглаа, боодолтой нь шатаахыг хориглоно. Тэсрэх бодисыг шатаахын өмнө дотор нь тэсэлгээний хэрэгсэл байгаа эсэхийг нарийн шалгана.

128. Түүдэгт шатаахаар бэлтгэсэн тэсрэх материалыг салхины дээд талаас нь 5 метрээс багагүй урттай гал дамжуулах шижим буюу түргэн асдаг материалын зурвасаар асаана. Зурвасыг асаасны дараа тэсэлгээчин хоргодох аюулгүй байранд орно.

129. Бүх бэлтгэл ажил дуусч, ажилчдыг аюулгүй зайд гарсны дараа түүдгээ асаана.

130. Тэсрэх материал шатааж буй түүдгийн гал унтраагүй байхад ойртохыг хориглоно.

131. Нитроэфир, гексоген агуулаагүй, усанд тэсвэргүй тэсрэх бодисыг тусгай төмөр торх болон түүнтэй адилтгах саванд хийж хүрээлэн буй орчинд хор хөнөөлгүй байхаар устгаж болно.

132. Уусаагүй үлдсэн тунадасыг шатааж устгана.

133. Устгал гүйцэтгэсэн ажилтан тэсрэх материал бүрэн устсаныг нягтлан шалгах үүрэгтэй.

134. Суларсан сав баглаанаас тэсрэх бодисын үлдэгдлийг сайтар цэвэрлэнэ. Дахин ашиглах боломжгүй болон шингэн ялгарсан ор мөртэй сав баглааг тэсрэх материалаас тусад нь шатааж устгана.

135. Тэсрэх материалыг дахин боловсруулж болох, эсэхийг зөвхөн үйлдвэрлэгч нь тогтооно.

136. Устгах, дахин боловсруулах тэсрэх материалыг орлого, зарлага бүртгэх журмын дагуу бүртгэнэ.

137. Боодлын гадарга дээр нь шингэн ялгарсан боодолтой тэсрэх бодисыг тавьж олгохыг хориглоно. 15%-иас дээш шингэн нитроэфирийн найрлагатай хөлдүү тэсрэх бодисыг хэрэглэх, халааж гэсгээхийг хориглоно.

## **Тэсрэх материалыг ачиж буулгах, тээвэрлэх ерөнхий шаардлага**



Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага

138. Тэсрэх материал хүлээж авах, ачих буулгах ажлыг тусгайлан гаргасан харуул хамгаалалт бүхий ачилт, буулгалтын талбайд тэсэлгээний ажил удирдагчийн хяналтын дор гүйцэтгэнэ.

139. Ачилт, буулгалтын талбайг төслийн дагуу тоногдсон байх бөгөөд хамааралгүй хүн ачилт, буулгалтын талбайд орохыг хориглоно.

140. Байгууллага нь ачилт, буулгалтын талбайд тэсрэх материал хүлээн авах үед ирж буй бүх тэсрэх материалын тоо хэмжээг хянаж бүртгэнэ.

141. Ачилт, буулгалтын талбай нь:

а) тэсрэх материал ачих, буулгах газрын гэрэлтүүлгийн цахилгаан хэлхээний ердийн таслуурыг 50 метрээс багагүй зайд байрлуулсан байх; (Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмэлт орсон)

б) цагдаа, онцгой байдлын байгууллагатай холбогдох холбооны хэрэгсэлтэй байх;

в) тэсрэх материалыг вагонд ачих, буулгах талбай нь орон сууц, үйлдвэрлэлийн байгууламж болон төв төмөр замаас 125 метрээс багагүй зайд байрласан байх.

142. Тэсрэх бодисын үйлдвэрээс агуулах хүртэл тэсрэх материалын агуулахаас тэсэлгээний ажлын байр хүртэл тэсрэх материалыг байгууллагын удирдлагын эсхүл түүний томилсон эрх бүхий албан тушаалтны тогтоосон маршрутаар тээвэрлэнэ.

143. Тэсрэх материалыг ажлын байранд хүргэхдээ зөвхөн зориулалтын тээврийн хэрэгсэл ашиглана. Тэсрэх материал тээвэрлэсэн тээврийн хэрэгслээр гадны хүн зорчихыг хориглоно.

144. Далд уурхайд тэсрэх материал тээвэрлэхээр зориулан тоногдсон бүх төрлийн тээврийн хэрэгсэл ашиглаж болно.

145. Далд уурхайд тротил, гексоген, шингэн нитроэфир агуулсан мөхлөгжүүлсэн тэсрэх бодисыг өөрийнх нь жингээр хоолойгоор урсгаж буулгахыг хориглоно.

146. Далд уурхайн гол амаар хүн тээвэрлэж байх үед тэсрэх материал тээвэрлэхийг хориглоно. Тэсрэх материалыг гол амаар тээвэрлэж ачих, буулгах үед гол амны дээрх барилга болон тухайн түвшний орчимд уг ажилтай холбогдолгүй хүн байлгахыг хориглоно.

147. Далд уурхайн босоо амаар тэсрэх материалыг оруулах, гаргахдаа өргөх машины машинч, уурхайн амны дохиочин, өргөлтийг хариуцсан бусад ажилчдад заавал урьдчилан мэдэгдсэн байна.

148. Сав, баглаа, боодолтой тэсрэх материалыг өргөх машинаар тээвэрлэхдээ клетний өндрийн 2/3-оос илүүгүй өндөртэй, гэхдээ түүний хаалганаас өндөргүйгээр ачна.

149. Тэсэлгээний хэрэгслийг тэсрэх бодисоос тусад нь уурхайд оруулж, гаргана.

Тэслүүртэй хайрцаг, цүнхийг тээвэрлэхдээ үйлдвэрлэгчийн зааварчилгааг дагах ба зааварчилгаагүй нөхцөлд давхарлахгүй нэг үе байрлуулна. (Энэ заалтыг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан)

150. Тэсрэх материал бүхий цүнх, савтай тэсэлгээчинг налуу малталтаар оруулах, гаргахдаа хүн зөөврийн тэргэнцэрийн нэг суудалд зөвхөн нэг тэсэлгээчин буюу туслах ажилчныг суулгана.

151. Клетэнд тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл бүхий цүнх, савтай хэд хэдэн тэсэлгээчин, туслах ажилчныг нэг зэрэг тээвэрлэхийг зөвшөөрнө. Ингэж зөөхдөө клетний 1 м<sup>2</sup> шаланд нэг хүн ногдохоор тооцно. Хүн бүрт ногдох тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл нь энэхүү дүрмийн 163-т зааснаас хэтрэхгүй хэмжээтэй байна.

152. Тэсрэх материалтай тэсэлгээчин, туслах ажилчныг дараалал харгалзахгүй

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага уурхайн гүнд оруулж, гаргана.

153. Тэсрэх материалыг газрын гүнд тээвэрлэх хурд 5 м/сек-ээс илүүгүй байна. Машинч нь тэсрэх материал ачсан клет, дамарт татлага, цахилгаан зүтгүүрийг аажмаар хөдөлгөж, зогсооно.

154. Газрын доорх малталтад тэсрэх материалыг хүргэхэд дараахь нөхцөлийг хангана. Үүнд:

- а) тэсрэх материалыг ачих, буулгах ажлыг зөвхөн тогтоосон газарт гүйцэтгэх;
- б) ослын тохиолдолд тэсрэх материалыг ачих, буулгах газрыг тэсэлгээний ажлын удирдагч тогтооно;
- в) тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг нэг цуваанд өөр өөр тэргэнцэрт тээвэрлэж болно. Энэ тохиолдолд тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй тэргэнцрүүд нь хоорондоо болон цахилгаан тэрэгнээс хоосон тэргэнцрээр 3 метрээс багагүй урт зайд тусгаарлагдсан байна. Уг цуваанд өөр төрлийн ачаа тээвэрлэхийг хориглоно;
- г) тэслүүрийг модоор доторлосон, галд тэсвэртэй материалаар битүү тагласан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Тэсэлгээний хэрэгсэлтэй хайрцаг цүнхийг эсгийгээр зөөлөвчилсөн тусгай тэргэнцэрт дан эгнээгээр ачиж тээвэрлэнэ. Бусад төрлийн тэсрэх материалыг ердийн тэргэнцэрт ачиж тээвэрлэхийг зөвшөөрнө;
- д) тэсрэх материалыг цахилгаан зүтгүүртэй цуваагаар тээвэрлэхдээ тэргэнцэрийг галд тэсвэртэй материалаар битүү тагласан байна. Мөхлөгжүүлсэн тэсрэх бодисыг галд тэсвэртэй даавуугаар бүтээж тээвэрлэж болно;
- е) тэсрэх материал тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн цувааны өмнө болон эцэст онцгойлон анхааруулах гэрлэн дохиоллыг байрлуулж, дохионы утгыг бүх ажилчдад танилцуулсан байна;
- ё) уурхайн малталтаар тэсрэх материал тээвэрлэж яваа тээврийн хэрэгслийг өөдөөс нь явж байгаа бусад тээврийн хэрэгсэл болон явган зорчигчид хөдөлгөөнөө зогсоон өнгөрүүлнэ;
- ж) тэсрэх материал зөөх, тээвэрлэх ажилтай холбоотой далд уурхайн тээврийн хэрэгслийн жолооч, машинч, тэсэлгээчин, туслах ажилчдад ажил эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгсөн байна;
- з) тэсрэх материалыг төмөр замаар тээвэрлэхэд цахилгаан зүтгүүрийн бүхээгт машинчаас өөр уг ажилтай холбогдолгүй хүн байхыг хориглоно. Тэсрэх материал дагалдах ажилтнуудыг цувааны төгсгөлийн суудлын тэргэнцэрт суулгана. Цувааны хурд дагаж яваа хүний дундаж хурдаас хэтрэхгүй байна;
- и) тэсрэх материалын агуулахад битүүмжилж лацадсан тусгайлан тоногдсон тэргэнцэр, чингэлэг, бусад савтай тэсрэх материалыг дагалдах ажилтангүйгээр хүргэж болно;
- к) тэсрэх материал тээвэрлэлтэд оролцож байгаа ажилтан амь хамгаалах багтай байна.

155. Томилогдсон ажилтан тэсрэх материал тээвэрлэх тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг сар, ээлж тутам шалгаж байна. Тэсрэх бодис буулгах зориулалттай хоолой, хаалт, сав, тоног төхөөрөмжид байгууллагын баталсан журмын дагуу үзлэг, үйлчилгээ хийж байна.

156. Уурхайн амны гаднах тэсрэх материал ачих талбай нь хаалт хамгаалалт, таних тэмдэгтэй байна.

157. Далд малталтад тэсрэх материал ачсан цувааг тэсэлгээний мөргөцөгт шууд хүргэх буюу тусгайлан тоногдсон зогсоолтой малталтад хүргэнэ. Тэсрэх бодис

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага төвлөрсөн ажлын байранд 4-өөс цөөнгүй хөөсөн галын хор болон галын усны шугаманд холбосон галын хошуутай байна.

158. Тэсрэх материалыг далд малталтаар тээвэрлэхэд цахилгаан зүтгүүрийн машинч болон тэсрэх материал дагалдан хүргэх ажилтнуудын хооронд мөрдөх дохиог байгууллагын удирдлага эсхүл тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч батална.

159. Шурф малтах үед гар лебедкаар тэсрэх материал буулгах, гаргахад дараахь нөхцөлийг хангана:

- а) мөргөцөгт тэсэлгээний ажилд холбогдолгүй хүн байхыг хориглох;
- б) тэсрэх материал оруулах, гаргах ажлыг 2-оос доошгүй хүн гүйцэтгэх;
- в) лебедка нь шүдэт түгжих төхөөрөмж буюу автомат тормозны аппараттай, холбох дэгээ нь түгжээтэй байх;
- г) тэсрэх бодис, өдөөх хэрэгслийг тус тусад нь оруулж, гаргана.

160. Тэсрэх материалыг босоо малталтаар лебедкийн тусламжтайгаар буулгаж, гаргахдаа тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчийн баталсан ажлын даалгавар, лебедка байрлуулах паспортын дагуу гүйцэтгэнэ.

161. Тэсрэх бодис, өдөөх хэрэгслийг тэсэлгээ хийх ажлын байранд гараар зөөж хүргэхдээ тус тусад нь цүнхтэй болон үйлдвэрийн сав баглаатай нь зөөнө.

162. Өдөөх хэрэгсэл болон тэслүүртэй бүүстер, галлагчийг зөвхөн тэсэлгээчин дотор талыг нь зөөлөвчилсөн хатуу дайз, хайрцагтай цүнхэнд хийж зөөнө.

163. Тэсэлгээчин тэсрэх бодис ба тэсэлгээний хэрэгслийг хамтад нь гараар зөөхөд тэсрэх материалын нийт жин 12 кг-аас хэтрэхгүй байна. Тэслүүртэй бүүстрийн жин 10 кг-аас хэтрэхгүй байна.

164. 25 кг хүртэл жинтэй тэсрэх бодисыг өдөөх хэрэгсэлгүйгээр зөөж болно.

165. Жин нь гараар зөөх зөвшөөрөх хэмжээнээс хэтрээгүй тэсрэх бодисыг үйлдвэрийн сав баглаатай нь зөөнө.

166. Тэсрэх материал тээвэрлэх авто тээврийн хэрэгсэл нь “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам”-ын шаардлага хангасан байна.

167. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг авто зам, төмөр зам, усан зам, агаараар тээвэрлэхдээ тухайн тээврийн төрөлд зориулсан аюулгүй ажиллагааны дүрмийг баримтална.

### **Тэсэлгээний ажил гүйцэтгэх ерөнхий шаардлага**

168. Ажлын байранд хүргэсэн тэсрэх материал нь цүнх, дайз болон үйлдвэрийн сав баглаа, тусгай зориулалтын машин, контейнерт савласан байна.

169. Ажлын байран дахь тэсрэх бодис болон цэнэглэсэн шпур, цооногийг харуул хамгаалалт, хяналтгүй орхихыг хориглоно. Харуул хамгаалалт, хяналтын журмыг тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллага тогтооно.

170. Ил уурхайн тэсэлгээний блок дээр байгаа тэсрэх материал болон цэнэглэсэн цооног шөнийн цагт гэрэлтүүлэгтэй байна. Тэсрэх материалыг хур тунадаснаас хамгаална.

171. Хүн ам оршин суух газарт болон барилга байгууламжийн дотор тэсэлгээний ажил хийхдээ тэсрэх материалыг тусгаарласан, харуул хамгаалалттай тасалгаанд байлгана.

172. Цэнэглэлтийн ажил эхлэх хүртэл хоногийн хэрэгцээний тэсрэх материалыг хориотой бүсийн гадна, ээлжийн хэрэгцээний тэсрэх материалыг хамгаалалтын бүсэд хадгалж болно. Өдөөх хэрэгсэл болон бэлтгэсэн бүүстрийг тэдгээрээс тэсрэлт дамжих

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага зайн гадна тусад нь хадгална.

173. Ачаатай цэнэглэгч машиныг тэсрэх материалын агуулахын болон тэсрэх материал бэлтгэх үйлдвэрийн тусгайлсан талбайд 2 хоног хүртэл хугацаатай хадгалж болно.

174. Босоо болон хэвтээ амны малталт нэвтрэх үед газрын гадарга дээрх малталтын ам болон бусад барилга байгууламжаас 50 метрээс багагүй зайд байрлах байранд ээлжийн хэрэгцээний тэсрэх материалыг хадгалж болно.

175. Тэсрэх материалтай харьцахдаа тэдгээрийг хэрэглэх заавар, аюулгүй ажиллагаа, галын аюулгүйн зааврыг чанд мөрдөнө.

176. Тэсрэх материал байгаа газраас 100 метрээс дотогш ил гал гаргахыг хориглоно. Галын аргаар тэсэлгээ хийж байгаа тэсэлгээчинд асаах хэрэгсэлтэй байхыг, харуулын ажилтныг галт зэвсэгтэй байхыг зөвшөөрнө.

177. Зайлшгүй тохиолдолд ил гал гаргах бол тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчийн баталсан онцгой ажлын даалгаврын дагуу гүйцэтгэнэ.

178. Нухаж няцлах боломжгүй барьцалдаж хатуурсан, гексоген болон шингэн нитроэфир агуулаагүй тэсрэх бодисыг энэхүү дүрмийн шаардлагын дагуу нунтаглах бөгөөд дараа нь зөвхөн хий, тоосны аюулгүй далд уурхай, тоосны тэсрэлтийн аюулгүй давхарга ашиглах болон газрын гадарга дээрх тэсэлгээний ажилд хэрэглэнэ.

179. Гексоген болон шингэн нитроэфир агуулсан, барьцалдаж хатуурсан тэсрэх бодисыг няцалж нунтаглалгүйгээр зөвхөн газрын гадарга дээрх тэсэлгээний ажилд хэрэглэнэ.

180. Хий, тоосны аюултай далд уурхай, тоосны тэсрэлтийн аюултай давхарга ашиглах тэсэлгээний ажилд боодол нь цоорч гэмтсэн тэсрэх бодис хэрэглэхийг хориглоно.

181. Тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллага нь тэсрэх материалтай харьцах ажилтнуудын аюулгүй байдлыг хангах, ажилчдыг тэсрэх бодисын тоос, тэсрэлтээс үүссэн хорт хийнээс хордохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний баримт бичгийг баталж, мөрдөнө.

182. Тэсэлгээний ажлыг тэсэлгээний ажлын удирдагчийн бичгээр өгсөн үүрэг даалгавар болон тэсэлгээний ажлын паспорттой (энэхүү дүрмийн хавсралт 7, 8, 9, 11, 12-т заасан маягтууд) танилцаж, гарын үсэг зурсан тэсэлгээчин гүйцэтгэнэ. Тэсэлгээний ажил явуулах газар нь тэсэлгээг аюулгүй гүйцэтгэх шаардлага хангасан байна.

183. Тэсрэх материалтай харьцах ажилтны хувцас цахилгаанждаггүй (статик гүйдэл хуримтлуулдаггүй) байх ёстой.

184. Тэсэлгээний ажлыг тогтоосон журмаар боловсруулж баталсан тэсэлгээний ажлын төсөл, паспортын дагуу гүйцэтгэнэ.

185. Цооногийн, камерын, тогоон цэнэгээр тэсэлгээ хийхийн тулд өрөмдлөг, тэсэлгээний ажлын төсөл, паспорт зохионо. Түүнчлэн барилгын объектын тэсэлгээний ажил, барилга байгууламж нураах, усны ёроол гүнзгийлэх, усан доор тэслэх, халуун масс тэслэх, чичирхийллийн хайгуул, цөмлөх-дэлбэлэх зэрэг тусгай тэсэлгээний ажлыг төсөл боловсруулж гүйцэтгэнэ.

186. Тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллага нь бөөнөөр тэслэх өрөмдлөг, тэсэлгээний ажлын жишиг төсөл, тухайлан тодорхой нөхцөлд гүйцэтгэдэг тэсэлгээний ажлын төсөл боловсруулж мөрдөж ажиллана. Жишиг төслийг тухайн ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл, туршилтын болон үйлдвэрлэлийн тэсэлгээний ажлын үр дүн, шинжлэх ухаан техникийн судалгаа, ижил төстэй нөхцөл дэх үйлдвэрлэлийн тэсэлгээний ажлын туршлага болон энэхүү дүрмийн шаардлагад үндэслэн боловсруулна.

187. Төсөлд:

- Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага
- а) өрөмдлөг, тэсэлгээний ажлын үндсэн хэмжээсүүд;
  - б) цэнэгийг өдөөх арга;
  - в) тэсэлгээний хэлхээний (дараалал, удаашралын хугацаа) тооцоо;
  - г) цэнэгийн бүтэц, бүүстрийн байрлал;
  - д) тэсрэх материалын зарцуулалтын тооцоо;
  - е) тэсэлгээний нөлөөллийн хүрээнд байрлах объектын (барилга, байгууламж, шугам хэлхээ) аюулгүй байдлыг хангах аюултай бүсийн тооцоо, хамгаалах арга;
  - ё) тэсэлгээний бүсийг агааржуулах болон энэхүү дүрэмд заасан аюулгүй ажиллагааны бусад арга хэмжээг зааж, өрөмдлөг, тэсэлгээний ажлыг аюулгүй зохион байгуулах шийдлийг тусгасан байна.

188. Тэсэлгээний ажлын паспортод:

- а) шпурын болон ил цэнэгийн байрлал, тэсрэх материалын нэр, шпурын тоо, гүн, диаметр, цэнэг болон бүүстрийн бүтэц, жин, цэнэглэх арга, цэнэгийг тэслэх дараалал, түгжээсний материал, түгжээсний урт, тэсэлгээний хэлхээ (цахилгаан хэлхээ), тэдгээрийн холболтын урт (цахилгаан хэлхээний эсэргүүцэл), удаашралын хугацаа, мөргөцгийн агааржуулалтын схем, хугацаа;
- б) аюултай бүсийн хүрээ;
- в) тэсэлгээ явагдах үеийн аюултай бүсийн гаднах тэсэлгээчний байрлал;
- г) харуулын байршил, аюултай бүс болон тэсэлгээ хийх газар руу нэвтрэхээс хамгаалах төхөөрөмж, анхааруулах, хориглох тэмдгийн байршлыг заана.

Түүнээс гадна хий, тоосны тэсрэлтийн аюултай уурхайд тэсрэлтээс урьдчилан сэргийлэх тусгай хэрэгслийн байршлын схем, авах тусгай арга хэмжээг тусгана. Паспортыг 3-аас доошгүй туршилтын тэсэлгээний үр дүнд тулгуурлаж боловсруулна. Туршилтын тэсэлгээний оронд ижил нөхцөлд явагдсан тэсэлгээний үр дүнг ашиглаж болно. (Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмэлт орсон)

189. Тэсэлгээний ажлын төсөл, паспортыг тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч, эсхүл түүний томилсон эрх бүхий ажилтан, харин тэсэлгээний ажил гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчээр ажиллаж байгаа тохиолдолд захиалагч байгууллагын тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч, эсхүл түүний томилсон эрх бүхий ажилтан батална.

190. Малталтын хүрээг төсөлд заасан хэмжээнд хүртэл засах, хана таазанд үүссэн оворыг унагах, мөргөцгийн хана, ул тэгшлэх, бэхэлгээ хийхээр малталт өргөсгөх болон туршилтын нэг удаагийн тэсэлгээний паспортыг тэсэлгээний ажлын удирдагч зохиож баталж болно. Харин хий, тоосны аюултай далд уурхайд тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчаар батлуулна. Паспортод шпурын байршил, цэнэгийн жин, бүтэц, харуулын болон тэсэлгээчний байрлал, шаардлагатай нэмэлт арга хэмжээг заана. Тэсэлгээчин паспорттой танилцаж гарын үсэг зурна.

191. Тэсэлгээний ажлын үед тэсрэх материалыг тэсэлгээ хийх газарт авч ирэх мөчөөс хамгаалалтын хориотой бүс тогтоож, цэнэглэлтийн ажилтай холбогдолгүй этгээд орохыг хориглоно.

Хамгаалалтын бүсэд гүйцэтгэгч, захиалагч байгууллагын болон хяналтын байгууллагын ажилтан зөвхөн тэсэлгээний ажлын удирдагчийг дагалдан нэвтрэхийг зөвшөөрнө.

Хамгаалалтын бүсийн хэмжээг өрөмдлөг, тэсэлгээний ажлын төсөл, паспортоор тогтооно.

Ил уурхайн тэсэлгээнд хамгаалалтын бүсийн хязгаарыг хамгийн ойрхон цэнэгээс 20 метрээс багагүй зайд тогтооно. Бүсийн хязгаарыг тухайн болон дээд, доод түвшинд

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага ойрын цэнэгээс хэвтээ чиглэлд мөн хэмжээгээр тооцон тогтооно.

Далд малталтад хамгаалалтын бүсийн хэмжээг байж болох цэнэгийн дээд хэмжээгээр тооцон энэхүү дүрмийн 455-ын е заалтын шаардлагаас бусад тохиолдолд 50 метрээс ойргүй зайд тогтооно. Хамгаалалтын бүсийг тэсэлгээний ажил явуулж буй малталттай холбогдсон бүх малталтад мөн хэмжээгээр тогтооно.

Ашиглалтын системийн онцлогоос шалтгаалан дээрх заалтыг ханган ажиллах боломжгүй тохиолдолд хориотой бүсийн хэмжээг Мэргэжлийн хяналтын төв байгууллагатай зөвшилцөн тэсэлгээний ажлын төсөл, паспортаар тогтооно. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор 8 дахь өгүүлбэрийг нэмсэн)

192. Аюултай бүсийг:

- а) тэсэлгээнд цахилгаан тэслүүртэй бүүстер хэрэглэх бол бүүстрийг цэнэгт байршуулж эхлэх үеэс;
- б) цочир дамжуулах шижим хэрэглэх бол тэсэлгээний хэлхээнд удаашруулагч реле холбохын өмнө;
- в) бага хүчин чадлын гуурстай цахилгаан бус тэслүүртэй бүүстер хэрэглэх бол хэсгийн холболтыг төв шугаманд холбох үеэс;
- г) өдөөлтийн электрон системтэй бүүстер хэрэглэх бол хэсгийн холболтыг төв шугаманд холбох үеэс тус тус хамгаалалтанд авна.

Хамгаалалтын болон аюултай бүсэд тавьсан харуулд үндсэн үүргээс нь өөр ажил давхардуулан өгөхийг хориглоно.

193. Далд уурхайн тэсэлгээнээс үүссэн утаа тоос гарах чиглэлийн малталтуудад аюултай бүсэд орохыг хориглосон тэмдэг тавина. Тэмдгийг тэсрэлтээс үүссэн хортой агаарын найрлага аюулгүй байх тэр зайд тавих бөгөөд энэ зайг мөргөцөгт хамгийн их тэсрэх бодис тэсэрсэн үед авсан агаарын сорьцын үр дүнгээр тогтооно. Тэсэлгээний дараа малталтуудыг бүрэн агааржуулж, заасан хаалт, тэмдгүүдийг хурааж авна.

194. Тэсэлгээний ажлын аюултай бүсэд бусад байгууллагын объект орохоор байвал удирдлагад нь тэсэлгээний ажил хийх газар, хугацааны тухай нэг хоногоос багагүй хугацааны өмнө бичгээр мэдэгдэнэ.

195. Тэсэлгээний ажлын үед аюултай бүсэд орж байгаа объектын удирдлага нь бүх ажилчдыг аюулгүй зайд гаргасан тухайгаа тэсэлгээний ажлын удирдагчид заавал эргэж бичгээр мэдэгдэнэ.

196. Тэсэлгээний ажлын үед өгөх дуут дохио нь чанга дуулдахаар, гэрлэн дохио нь тэсэлгээний ажлын үед аюул гарч болзошгүй газруудад харагдахуйц байрлагдсан байна. Тэсэлгээний ажлын үед заавал дуут дохио ашиглана. Дуут дохиог өгөхдөө тэсэлгээний ажлын нөлөөллийн бүсийг бүрэн хамарч дуулдахаар зохион байгуулна. Дохиог амаар болон тэсрэх материал хэрэглэж өгөхийг хориглоно. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор 3 дахь өгүүлбэрийг нэмсэн)

Дохионы утга ба түүнийг өгөх зарчим:

- а) нэгдүгээр дохио - анхааруулах (нэг урт). Дохио өгч аюултай бүсийг хамгаалалтанд авна;
- б) хоёрдугаар дохио - тэслэх (хоёр урт). Энэ дохиогоор тэслэнэ;
- в) гуравдугаар дохио - тэсэлгээ дууссан (гурван богино). Тэсэлгээний ажил дууссаныг зарлана.

Дохиог тэсэлгээний ажил гүйцэтгэсэн тэсэлгээчин (ахлах тэсэлгээчин), харин бөөнөөр тэслэх үед тэсэлгээний ажил гүйцэтгэгч байгууллагын тусгайлан томилогдсон ажилтан өгнө.

197. Дохионы агуулга, зориулалт, өгөх арга, тэсэлгээний ажил явуулах хугацааг байгууллагын ажилтнуудад болон аюултай бүстэй залгаа нутаг дэвсгэрт амьдардаг хүн амд таниулсан байна.

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага

198. Тэсэлгээний ажлын удирдагч, эсхүл түүний даалгаснаар тэсэлгээчин нь тэсэлгээ хийсэн газрын аюулгүй болохыг тогтоож, уг газар руу хүн орох зөвшөөрлийг өгнө. 199. Цэнэглэхээр бэлтгэсэн шпур, цооног болон бусад малталтын амны орчмын шороо чулуу, өрмийн нунтаг, бусад зүйлийг сайтар цэвэрлэсэн байна. 200. Сүмбийг зөвхөн оч үүсгэхгүй материалаар хийнэ.

201. Цахилгаан тэслүүртэй бүүстер, галлагчийг шпур, цооногийн аман талд байрлуулна. Бүүстерт бага хүчин чадлын гуурстай цахилгаан бус тэслүүрийн өдөөлтийн систем хэрэглэсэн үед бүүстрийг шпур, цооногт уг системийн ашиглалтын зааврын дагуу байрлуулна. Механикжуулсан цэнэглэх төхөөрөмж хэрэглээгүй үед цахилгаан тэслүүртэй бүүстрийг шпур, цооногийн ёроол талд байрлуулж болно. Ингэхдээ цахилгаан тэслүүрийн хонгионы ёроолын хонхорхойг шпурын ам руу чиглүүлж байрлуулна. Нүүрс, занарын далд уурхайд шпур дахь цахилгаан тэслүүртэй бүүстрийн ийм байршлыг зөвхөн хийн ялгаралтгүй болон тэсрэмтгий тоосгүй тохиолдолд, цахилгаан тэслүүрийн утсыг шпурын амсраас гадагш 0.6 метрээс багагүй урттай байхад хэрэглэхийг зөвшөөрнө.

202. Гацсан бүүстер, галлагчийг цохиж оруулахыг хориглоно. Хэрэв гацсан бүүстер, галлагчийг гаргаж авах боломжгүй байвал шпур, цооногийн цэнэглэлтийг зогсоож, тэдгээрийг бусад цэнэгийн хамт тэсэлнэ.

203. Нүүрсний цулыг урьдчилан сийрэгжүүлэх тэсэлгээнд 5 метрээс илүү урттай шпур, цооногийг тууш болон тасалж байрлуулсан цэнэгээр цэнэглэж усан түгжээс хийсэн бол цочир дамжуулах шижмийг шпур, цооногийн амсраас цухуйлгалгүйгээр байрлуулан нэмэлт өдөөх хэрэгсэл ашиглаж болно.

204. Хий, тоосны аюултай далд уурхайн малталтын шатах хийн ялгаралгүй мөргөцөгт тасалж байрлуулсан цэнэгийг зөвхөн цөмлөх шпурт хэрэглэж болно.

205. Шпур, цооног цэнэглэх явцад цэнэгийн хэсэг нь асгарсан тохиолдолд шпур, цооногийг гүйцээж цэнэглээд нэмэлт цэнэгт заавал бортгон өдөөгчийг байрлуулж тэсэлнэ.

206. Цэнэг дэх бүүстэртэй холбогдсон цочир дамжуулах шижим, электрон, цахилгаан, цахилгаан бус тэслүүрийн утсыг угзарч татахыг хориглоно. Цэнэгээс гарч буй цочир дамжуулах шижмийн үзүүрийг нугалж, хугалахыг хориглоно.

207. Хий, тоосны аюултай далд уурхайд цэнэгийг түгжээсгүй тэслэхийг хориглоно.

208. Шпур, цооногийг түгжихдээ түүн доторх тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг гэмтээхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Түгжээс хийх үед цахилгааны утас, цочир дамжуулах шижим, цохилтын долгион дамжуулах гуурс татагдаагүй сул байна. Шпур, цооногийг хэт том ширхэглэлтэй болон халуун материалаар түгжиж болохгүй.

209. Шпур, цооногийг түгжээсний машинаар түгжихдээ тэдгээрийн ашиглалтын зааврыг мөрдөж ажиллана.

210. 1.5 метрээс өндөрт байрлах шпурыг цэнэглэх, тэсэлгээний хэлхээг холбох ажлыг зөвхөн мөргөцөгт тулгаж тогтоосон зориулалтын тавиур, тавцан болон цэнэглэх, холбох ажлыг аюулгүй, зөв хийх тохиромжтой нөхцөлийг хангасан өргөх механизмын тавцан дээрээс хийнэ. 1.5 метрээс өндөрт байрлах шпур, цооногийн цэнэглэлт, хэлхээний холболтыг шатан дээр байрлаж хийхийг хориглоно. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)

211. Ил цэнэгийг зэрэгцээ цэнэгээ гэмтээхгүй байхаар байрлуулна. Хэрэв тийм бололцоогүй бол цэнэгүүдийг тохирох өдөөх хэрэгслээр зэрэг тэсэлнэ. Ил цэнэгийг чулуу хайрга болон бусад том ширхэглэлтэй материалаар хучиж далдлахыг хориглоно.

212. Тэслэх цэнэгийн урт 10 метрээс илүү бол цооногийн доторх хэлхээг заавал хослуулж хийнэ. Газрын доорх малталтад хос хэлхээ хийхийг өрөмдлөг, тэсэлгээний ажлын төсөл, паспортаар тодорхойлно. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага

213. Хамгаалах хучлагатай бүлэг цэнэгийг нэгэн зэрэг буюу 200 м/с-ээс ихгүйгээр удаашралтайгаар тэсэлнэ. 214. Аянга цахилгаантай үед газрын гадарга дээр болон гадаргаас нэвтэрч буй далд малталтад цахилгаан тэсэлгээ хийхийг хориглоно. Хэрэв аянга цахилгаан эхлэхээс өмнө хэлхээг холбосон бол тэсэлгээг хийх, эсхүл хэсгийн холболтуудыг төв шугамаас салгаж үзүүрийг нь сайтар тусгаарлан, ажилчдыг аюулгүй бүсээс гаргах буюу хоргодох байранд оруулна.

215. Ил уурхайд шөнийн цагаар тэсэлгээний ажил хийхийг хориглоно. (Энэ заалтыг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан)

216. Нуранги, налуу гадарга дээрх цэнэглэлт, тэсэлгээний хэлхээний холболтыг зөвхөн газрын дээрээс доош чиглэлийн дарааллаар хийнэ.

217. Тэсэлгээний дараа гүйцэд авагдаагүй шпур, цооногийн ёроол руу, түүний дотор цэнэг байгаа эсэхээс үл хамааран өрөмдөхийг хориглоно.

218. Цооног, шпурт хий буудлага хийсний дараахь цэнэглэлтийг 30 минутаас багагүй хугацааны дараа дахин хэмжилт хийж цэнэглэлтийг хийнэ. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмэлт орсон)

219. Камерын цэнэгийг цочир дамжуулах шижим, цахилгаан тэслүүр, цахилгаан бус өдөөлтийн систем ашиглан тэсэлж болно. Цэнэгийн камер бүрт хоёр бүүстэр буюу галлагч хийх бөгөөд тэдгээрийг өдөөх, холбох арга нь ижил байна. Цэнэгийн камер дахь бүүстэр, галлагчийг хатуу бөх бүрхүүлтэй гэмтээхгүйгээр байрлуулна.

220. Камерын цэнэг байрлуулах малталтын цахилгаан дамжуулах шугамыг цэнэглэлт эхлэхийн өмнө хураасан байна.

221. Газрын дээрх цэнэгийг бөөнөөр тэслэх тэсэлгээнээс агаарын хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй бол холбогдох байгууллагатай зохих журмын дагуу зөвшилцсөний дараа тэсэлгээний ажлыг гүйцэтгэнэ.

### **Тэсрэх бодисыг үйлдвэрлэх ба хэрэглээнд бэлтгэх үйлдвэр, механикжуулсан цэгийн ашиглалтын аюулгүй ажиллагааны шаардлага**

557. Энэхүү дүрмээр үйлдвэрлэлийн зориулалттай энгийн ба эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэх, тэдгээр тэсрэх бодисыг үйлдвэрлэхэд орох завсрын найрлага, хольц, эмульс үйлдвэрлэх суурин ба зөөврийн үйлдвэр (цаашид “үйлдвэр” гэх) болон үйлдвэрийн гаралтай тэсрэх бодисыг хэрэглээнд бэлтгэх (үйлдвэрийн гаралтай тэсрэх бодисыг задлах, цэнэглэгч машинд ачих) байр байгуулах, тэдгээрийн ашиглалтад тавих шаардлагыг тогтооно. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмэлт орсон)

558. Газрын дээр болон далд уурхайд байрлах үйлдвэрлэлийн зориулалттай энгийн ба эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодисыг ашиглалтад бэлтгэх байруудад энэхүү дүрмийг мөрдөнө.

559. Зөөврийн цэнэглэгч машины эзэмшигч байгууллага нь уг машины ашиглалт, аюулгүй ажиллагааны зааврыг үйлдвэрлэгчийн ашиглалтын заавар болон энэхүү дүрмийн шаардлагыг үндэслэн боловсруулж мөрдөнө.

560. Тэсрэх бодисын үйлдвэрт дараахь төрлийн тэсрэх бодис үйлдвэрлэхийг зөвшөөрнө. Үүнд:

а) мөхлөгт аммиакийн шүүг шингэн, хатуу болон хуурай нефтийн бүтээгдэхүүн, нунтаг эсвэл өөр гарал үүслийн үл тэсрэх шатамхай материалтай хүйтэн аргаар хольсон механик хольц;

б) мөхлөгт аммиакийн шүүг хайрслаг тротил, шингэн, хатуу болон хуурай нефтийн бүтээгдэхүүн, нунтаг эсвэл өөр гарал үүслийн үл тэсрэх шатамхай материалтай хүйтэн аргаар хольсон механик хольц;



Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага

в) аммиакийн шүүний уусмал, эсвэл кальцийн болон натрийн шүү, карбамидын нэмэлттэй аммиакийн шүүний уусмал дээр суурилсан цийдмэг буюу эмульсийг нунтаг болон шингэн үл тэсрэх шатамхай материалтай найруулсан хольц;

г) тэсрэх бодисын төрөл дээрхээр хязгаарлагдахгүй бөгөөд бусад төрлийн тэсрэх бодис үйлдвэрлэх тохиолдолд тухайн тэсрэх бодис үйлдвэрлэх технологийг ашиглана. (Энэ дэд заалтыг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмсэн)

561. Хий, тоосны аюулгүй далд уурхайд тэсрэх бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх байрыг энэ зорилгоор тусгайлан бэлтгэж төхөөрөмжилсөн малталтад байрлуулна.

562. Газрын гадарга дээрх тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байрыг тэсрэх материалын агуулахын талбайд эсвэл тэсрэх материалын агуулахын хориотой бүсэд байгуулж болно. Ингэхдээ тэсрэх бодис үйлдвэрлэх болон бэлтгэх байрыг тэдгээрт нэг агшинд байж болох тэсрэх бодисын дээд хэмжээг идэвхтэй цэнэгээр авч тэсрэлт дамжуулахгүй зайг ачиж буулгах тавцан, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулах хүртэл тооцон, тэсрэх материалыг тээвэрлэх, ачиж буулгах зам талбайгаас аюулгүй зайд байрлуулахыг зөвшөөрнө. Тэсрэх бодисыг бэлтгэх байр болон тэсрэх бодисын үйлдвэр нь өөрийн хашаатай байна.

Ажилчдын гүйцэтгэж буй ажилтай нь холбоотой аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ, болзошгүй аюулыг анхааруулсан зурагт хуудас, мөн үйлдвэрийн бүсэд тээврийн хэрэгсэл болон явган хүний хөдөлгөөний чиглэл заасан схем, анхааруулах тэмдгүүдийг үзэгдэх орчин, гэрэлтүүлэг сайтай газарт барилга байгууламжийн хана, ажлын байранд болон тоног төхөөрөмж дээр байрлуулна.

563. Тэсрэх бодисын үйлдвэр болон тэсрэх бодис бэлтгэх байрыг нэг талбайд хамт байрлуулж болно. Ингэхдээ барилга байгууламжийн хоорондын зайг энэхүү дүрмийн 9 дүгээр бүлэгт заасан шаардлагаар тогтооно.

564. Тэсрэх бодис бэлтгэх байр, тэсрэх бодисын үйлдвэрийн барилгын хоорондын зай, мөн түүнчлэн үйлдвэр, тэсрэх материалын агуулахын хоорондын зайг тэдгээрийн хооронд тэсрэлт дамжихгүй байх нөхцөлөөр тооцож тогтооно.

565. Далд уурхайн малталтын дээр тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байр байрлуулах бол газрын гадаргыг цөмрөхөөс сэргийлэх (дүүргэж чигжих, нураах) арга хэмжээг урьдчилан авсан байна.

566. Газрын гадарга дээрх тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байрыг уулын ажил явагдаж байгаа малталтын дээр, мөн асга, цасны нуралтын аюултай уулын хажууд байрлуулахыг хориглоно.

567. Хүлрийн хурдасын давхаргатай газар тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодис бэлтгэх байрыг байрлуулах шаардлагатай бол хүлэр шатах тохиолдолд гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор үйлдвэрийн хашааг хүлрийн давхаргын захаас 200 метрээс багагүй зайд байрлуулах ба галын байгууллагатай зөвшилцөж, гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

568. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байрын гадуур тойруулан хамгаалалтын хашаа барьж, харуул хамгаалалттай байлгана. Хашаа, харуулын байрыг дүрмийн шаардлагаар тооцоолсон зураг төслийн дагуу барина.

569. Тэсрэх бодис бэлтгэх, дахин боловсруулах үйлдвэрийн болон эмульсийн үйлдвэрийн барилга байгууламжаас гадагш аюулгүйн зайг тэсрэх материалын агуулахын агаарын цохилтын долгионы үйлчлэлийг тооцох аргаар тодорхойлно. Ингэхдээ тэсрэх бодисын болон эмульсийн жинг тротилын эквивалентаар харьцуулж

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага тооцно.

570. Тэсрэх бодисын үйлдвэрийг барьж байгуулах талбайг газрын гадаргын тогтоц, гидрогеологийн нөхцөл, мөн цаашид өргөтгөх боломжийг харгалзан сонгоно. Схем дээр үйлдвэрийн үндсэн болон туслах барилга байгууламжуудыг тэсрэх бодис бэлтгэх, үйлдвэрлэх технологийн процессыг аюулгүй, үр ашигтай гүйцэтгэх нөхцөлийг хангасан байрлалтай, мөн зам талбай, орц, гарцыг хөдөлгөөнд зохистой, аюулгүй байхаар байрлуулсан байна.

571. Далд уурхайд тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх цэгийг далд уурхай дахь тэсрэх материалын агуулахын бүсэд байрлуулахыг зөвшөөрөх ба энэ тохиолдолд үйлдвэрийн бүх хонгилыг цэвэр агаарын урсгалаар агааржуулна. Үйлдвэрээс гарсан агаарыг цэвэр агаарын урсгалтай малталт руу оруулахыг хориглоно.

572. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх цэгийг усгүй, тогтвортой чулуулагтай газар байрлуулах ба дараахь байгууламжуудаас дор дурдсанаас багагүй зайтай байна. Үүнд:

а) хүн тээврийн вагоны зогсоол, уулын цул ачих цэгээс 50 метр;

б) уурхайн босоо ам, босоо амны байгууламжаас болон уурхай руу бүхэлд нь болон ихэнх хэсэг рүү нь цэвэр агаарын урсгалыг зохицуулдаг агааржуулалтын хаалганаас 100 метр;

в) газрын гадаргаас 30 метр;

г) ажилчид байнга явдаг малталтаас 25 метрээс багагүй байна.

573. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх цэг нь ажилчдад зориулсан үндсэн ба туслах хаалгатай байх бөгөөд тэдгээрт үндсэн болон туслах орцуудыг тоноглон ашиглаж болно. Аль нэг орцыг нь савтай шатах тослох материал оруулах болон хадгалах зориулалтаар ашиглаж болох бөгөөд, хажуугаар нь ажилчид чөлөөтэй нэвтрэх зай гаргасан байна.

574. Үйлдвэрийн барилга байгууламж, ажлын тасалгаануудын харагдахуйц газарт галын анхан шатны багаж хэрэгсэл, гал унтраагуурын байрлалыг заасан тэмдэглэгээ, галын дохиоллын системийг ажиллуулах товчлуур мөн үйлдвэрлэлийн аюулын зэрэглэлийг заасан тэмдэг, тэмдэглэгээг байрлуулна.

575. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх талбайд ил гал гаргахыг хориглоно.

576. Үйлдвэрийн аюултай бүсийн хүрээнд зөвхөн үйлдвэрийн болон туслах барилга байгууламж тэдгээрт хамаарах шугам сүлжээ байрлана.

577. Газрын дээрх, тухайн байгууллагатай холбоогүй хий, газрын тосны шугам хоолойноос тэсрэх бодис үйлдвэрлэх барилга байгууламж хүртэлх зайг холбогдох 71 норм, дүрмээр тодорхойлох бөгөөд агаарын долгионы цохилтын аюулгүй бүсээс багагүй байна.

578. Аюулгүйн зайг тооцохдоо үйлдвэрийн бүсэд байрлах тэсрэх бодисын хамгийн их хэмжээг авч тооцох ба аваарын нөхцөлд нэгэн зэрэг тэсрэх магадлалыг авч үзнэ.

Хуурай болон уусмал байдлаар байгаа аммиакийн шүү, кальцийн шүү, нитрит натри зэргийг тооцохгүй. Үйлдвэрийн эмульсжүүлэгч аппарат болон цэнэглэгч машины хооронд тэсрэлт дамжихаас хамгаалах төхөөрөмжтэй буюу эмульсжүүлэгч аппаратын эвдрэлээс үүссэн металлын хэлтэрхийг цэнэглэгч машины эмульсийн саванд орохоос хамгаалах төхөөрөмжтэй бол цэнэглэгч машин дахь эмульсийг тооцоонд оруулахгүй.

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага

Зөөврийн сав (цэнэглэгч машин)-тай эмульсийг үйлдвэрийн талбайд тэсрэлт дамжихгүй байх аюулгүйн зайг тооцсон зайднд байрлуулж болно.

579. Тэсрэх бодисын үйлдвэр, бэлтгэх байрнаас хүн тогтмол ажилладаггүй туслах барилга, байгууламж хүртэлх зай мөн тухайн туслах барилга байгууламж хоорондын зайг барилгын норм ба дүрэмд заасны дагуу тооцно.

580. Аммиакийн шүү хадгалах байр нь мөхлөгжүүлсэн аммиакийн шүүг үйлдвэрлэлд бэлтгэх (шигших, бутлах, шүүний уусмал бэлтгэх) тасалгаатай үргэлж байж болно. Шүү хадгалах байрыг бэлтгэлийн тасалгаанаас ханаар тусгаарлана.

581. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байрыг галын дохиоллоор тоногдсон, холбооны нэгдсэн сүлжээтэй байхын зэрэгцээ харуул хамгаалалт нь бие даасан холбооны сүлжээтэй байна. Далд уурхайд байрлах тэсрэх бодисын суурин үйлдвэр нь уурхайн диспетчертэй холбоо барих төхөөрөмжтэй байна.

582. Тэсрэлтийн болон галын аюултай тоос, уур, хий гарах нөхцөл бүхий ажлын байранд ашиглах холбооны хэрэгсэл, чанга яригч зэрэг нь стандартын шаардлага хангасан байна.

583. Утсан холбоо бүхий чанга яригчийг тэсрэлт, галын аюулгүй ажлын байранд ашиглаж болно.

584. Үйлдвэрийн тэсрэх, шатах аюултай ажлын байр нь галын аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу тоногдсон галын дохиолол, телефон утастай байна.

585. Үйлдвэрийн барилга байгууламж, түүний гаднах тоноглол, төхөөрөмжийг аянгын шууд болон хоёрдогч үйлчлэлээс хамгаалах тооцоог энэхүү дүрмийн шаардлагын дагуу хийнэ.

Аянгын хамгаалалтаар тоноглогдсон барилгад холбогдсон бүх төрлийн харилцаа холбоо, дохиоллын сүлжээг (утсан болон агаарын кабель) агаарын шугамаар гүйцэтгэхийг хориглоно.

586. Сүлжээний гол хэсгүүдийг утасны сувгийн системд байрлуулж, түгээлтийн сүлжээг хамгаалалттай кабелиар хийнэ.

587. Тэсрэх бодисын үйлдвэрийн барилга нь 2-оос доошгүй хаалга, гарцтай байх бөгөөд галын болон тэсрэлтийн аюул үүссэн тохиолдолд ажилчдыг гаргах, нүүлгэн шилжүүлэх боломжоор хангагдсан байна.

588. Шатамхай бодис, галын болон тэсрэлтийн аюултай бодисын тоосжилт үүсч болзошгүй барилгад байнга хянаж байх боломжгүй нүх, цоорхой бүхий хийц эдлэл ашиглахыг хориглоно.

589. Үйлдвэрийн барилгын шал нь зай завсаргүй, ус зайлуулах сувагтай байна. Исэлдүүлэгч бодис бэлтгэх, түүгээр тэсрэх бодис үйлдвэрлэх, хадгалах байрны шал болон барилгын хийцийг хүчилд тэсвэртэй будгаар будаж хамгаална.

590. Тэсрэх бодис, хагас боловсруулсан бүтээгдэхүүн эсвэл тэсрэх бодисын хольцууд байрлах барилга байгууламж, ажлын байр бүрийн ачааллын нормыг баталгаажуулж, хүснэгт хэлбэрээр хийж эдгээр барилга байгууламжид болон ажлын байранд байрлуулсан байна. Галын болон тэсрэлтийн аюултай бүтээгдэхүүн байрлуулах газрыг шалан дээр тод будгаар ялган зааж тэмдэглэсэн байна.

591. Туршилтын болон тэсрэх материалын хаягдал, үйлдвэрлэлийн гологдлыг устгах талбайг тэсрэх бодис үйлдвэр, түүний ойролцоо хүн ам оршин суух газар, авто зам, инженерийн шугам сүлжээнд аюул учруулахгүй зай, байрлалыг тооцон сонгож

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага байгуулна.

Объектоос тэсрэх материалыг тэсэлж, шатааж устгах талбай хүртэлх зайг төслөөр тооцно. Тэсрэлтийн аюултай бүтээгдэхүүнийг талбайд хүргэх аюулгүй зам, гарцыг мөн урьдчилан тооцсон байна. Тухайн талбайн эргэн тойрны 10 метр зайд өвс ургамал, гадны гаралтай шатамхай материалыг бүрэн цэвэрлэнэ.

592. Талбайг хашаагаар хамгаалж, хашаанаас гадагш 25 метрийн зайд анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ тавьсан анхааруулах бүстэй байна.

593. Талбайг хүлэржсэн газарт байршуулахыг хориглоно.

594. Туршилт, устгалын ажлыг гүйцэтгэхдээ аюулгүй байдлыг хангах ажиллах шаардлагатай.

595. Туршилт хийх, эсвэл устгалын ажлыг гүйцэтгэх үеийн аюулгүй байдлыг хангах зорилгоор талбайг дараахь байдлаар тоноглоно. Үүнд:

а) хоргодох байр;

б) тэсрэх материалыг хамгаалах байр;

в) хоргодох эсвэл хамгаалах байрны хаалга нь шатаах эсвэл тэсэлгээ хийх газрын эсрэг чиглэл рүү харсан байна.

596. Тэсрэх материалын хаягдал, үйлдвэрлэлийн гологдлыг шатааж, тэсэлж эсвэл уусгаж устгаж болно.

597. Аюул ослын магадлал өндөртэй туршилт устгалын ажлыг байгууламжаас аль болох зайтай, талбайн төв хэсэгт хийнэ.

598. Талбайг харилцаа холбооны хэрэгсэл болон дуут дохиогоор тоноглох, тэсрэх материал тээвэрлэх замын асуудлыг зураг төсөлд тооцож шийдсэн байна.

599. Тэсрэх материал тээвэрлэх замыг дараахь зайнд тооцож хийнэ. Үүнд:

а) тэсрэх бодисын үйлдвэрээс 15 метрээс багагүй;

б) хэрэв зам нь тухайн үйлдвэрт орж, гарах зориулалттай бол үйлдвэрийн барилгаас 3 метрээс багагүй;

в) ил галын эх үүсвэр бүхий газар, эсвэл ил галтай ажил гүйцэтгэдэг газар (дархан, гагнуур, уурын зуух г.м), мөн шатахууны болон шатах тослох материалын агуулах зэргээс 50 метрээс багагүй;

г) үйлдвэрийн орчин, бүсэд байрлах туслах барилга байгууламжаас 15 метрээс багагүй;

д) барилгын норм дүрмээр хол зайд байхыг шаардаагүй бусад барилга байгууламжаас 6 метрээс багагүй.

600. Тэсрэх бодис бэлтгэх, дахин боловсруулах байранд энэхүү дүрмийн 166 дугаар зүйлийн шаардлагын дагуу тоногдсон тээврийн хэрэгсэл орохыг зөвшөөрнө.

601. Үйлдвэрийн ачаа хүлээж авах, ачих төхөөрөмж, байгууламж руу хольж цэнэглэгч машин, түүнчлэн тэсрэх материал болон эмульс үйлдвэрлэхэд ордог хольц, бүрэлдэхүүн хэсгүүдийг тээвэрлэх зориулалтаар тусгайлан тоноглож, ашиглахыг зөвшөөрсөн автомашин, ачиж буулгах төхөөрөмжид орох зөвшөөрөл олгоно.

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага

602. Тэсрэх бодисын тоосжилттой байж болох барилга байгууламжид төмөр замын вагон тавих зүтгүүрийг 10 метрээс дотогш ойртуулахыг хориглоно.

603. Вагоныг хөдөлгөхийн өмнө хаалгыг нь хааж түгжсэн байна. Аюултай ачаатай төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хурд үйлдвэрийн талбайд 15 км/цагаас илүүгүй байна. Аюултай ачаатай вагоныг огцом түлхэх, татах, огцом зогсоохгүйгээр холбож, салгаж найруулна.

604. Тэсрэх бодис бэлтгэх байр руу тэсрэх бодис ачсан нэг вагон (задгай вагон, платформ)-ыг ачааг нь үйлдвэрлэлийн шугаманд шууд буулгахаар тавьж болно.

605. Аккумулятор цэнэглэх байрыг тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байрнаас 50 метрээс багагүй зайд байрлуулна.

606. Үйлдвэрлэлийн технологийн процессын удирдамжид үйлдвэрлэлийн болон галын аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн ариун цэвэр эрүүл ахуйг сахих, үйлдвэрлэлийн хорт хаягдлыг барих, статик цахилгаанжилтаас хамгаалах ажиллагааны шаардлагуудыг тусгасан байна.

607. Дээр дурдсанаас гадна үйлдвэрлэлийн технологийн процессын удирдамжид дараахь асуудлуудыг тусгасан байна. Үүнд:

а) үйлдвэрлэлийн процессын иж бүрэн механикжуулалт, автоматжуулалт;

б) үйлдвэрлэлийн процессын өгөгдсөн дараалал, түүнчлэн тоног төхөөрөмжийн ажиллагааны горимыг хангах тоног төхөөрөмж, удирдлагын механизм;

в) үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, аппаратаасаас оч дөл авалцаж шатах, тэсэрч дэлбэрэх аюултай хий, уур, тоосны ялгаралтыг гаргахгүй байх буюу хамгийн бага түвшинд байлгахаар битүүмжлэх;

г) тоосромтгой түүхий эд, материалыг шилжүүлэн зөөх, тээвэрлэхэд хаалт, таглаатай тоног төхөөрөмж ашиглах;

д) үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас ялгарах хорт хий, хаягдлыг агаарт цацагдахаас өмнө шүүх, цэвэрлэх тоног төхөөрөмж ашиглах;

е) технологийн процесст эргэлтийн ус ашиглах;

ё) ашигласан усыг гадагшлуулахын өмнө тунадасыг цуглуулах, устгах;

ж) хаягдал дахь хорт бодисын агуулгыг зөвшөөрөгдөх хамгийн бага хэмжээнд хүргэх, бүрмөсөн устгах асуудлуудын шийдлийг тусгасан байна.

608. Нэг барилга дахь үйлдвэрлэлийн технологийн процесс, фаз нь өөр өөр аюулын зэрэглэлтэй бол процесс, фаз тус бүрт нь тохирсон гал тархахаас хамгаалах тоноглол, хэрэгслээр төхөөрөмжилнө (галын хамгаалалттай хана, зай завсарыг бөглөх, хамгаалалт хийх г.м).

Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх үйлдвэрийн технологийн процессын удирдамж боловсруулахдаа хорт хийн ялгаралт, хамт хадгалж болохгүй бодис бүтээгдэхүүн зэргээс шалтгаалж тусгаарласан байранд байрлуулах шаардлагатай технологийн дамжлагыг тодорхойлж, уг баримт бичигт тусгана.

Натрийн нитритийн усан уусмал бэлтгэх байр нь исэлдүүлэгч уусмал болон хольцуудыг бэлтгэх байрнаас тусгаарлагдсан, тусдаа байранд өөрийн гэсэн орох хаалга, ачих талбайтай байна.

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага

609. Орчны агаарын температурт талсжих эсвэл хөрөх онцлогтой бодис боловсруулах сав, тоног төхөөрөмж, мөн бүтээгдэхүүн дамжуулах шугам хоолой, агуулах савыг дулаан алдагдахаас хамгаалж, халаах төхөөрөмжөөр төхөөрөмжилнө.

610. Тэсрэлтийн болон галын аюултай тоос ялгаруулдаг байр тасалгаанд шугам хоолойг барилга руу оруулахдаа халаалтын системийн сувагт тоос нэвтрэн орж хуралдахаас сэргийлж, хоолой орсон хэсгийг чигжиж битүү хамгаалалт хийнэ.

611. Технологийн тоног төхөөрөмжийг зарцуулах ба хадгалах савтай холбосон шингэн дамжуулах хоолойнууд нь аль болох цөөн нугаралттай байх ба төсөлд тэдгээрийн бүрэн шавхагдах нөхцөлийг тооцсон байна.

612. Тэсрэх бодис, исэлдүүлэгч бодисын сав баглаа боодлыг ээлжийн хугацаанд үйлдвэрийн барилгын гадна талын цонхгүй хэсэгт, саравчин доор түр хадгалж болно. Хэрэв ажлын байранд түр хадгалах бол аваарийн гарц, замыг хаахгүйгээр тусгайлан байр гаргаж, 2 цагийн хэрэглээг хангах хэмжээгээр хадгалахыг зөвшөөрнө.

613. Тээврийн хэрэгслийг үйлдвэрийн барилгын дэргэд зөвхөн ачилт, буулгалтын ажлын үед түр зогсохыг зөвшөөрнө.

614. Тэсрэх материалын агуулах болон тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх ажиллагаа явагдаж байгаа үйлдвэрийн байрнаас бусад байранд бага хэмжээний болон урсгал засвар хийх зориулалттай засварын (гагнуурын төхөөрөмжгүй) байр, мөн жижүүрийн засварчин, цахилгаанчин түр байрлах байр байж болно. Эдгээр нь үйлдвэрлэлийн байрнаас галаас хамгаалах ханаар тусгаарлагдсан, тусдаа өрөөнд байрлана.

615. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх ажиллагаа явуулж байгаа байрны тэсрэх бодисын нийт ачаалал нь вагон, хольж цэнэглэгч машин, бусад тээврийн хэрэгсэл, нөөцийн саванд байгаа нийт тэсрэх бодисын хэмжээг оролцуулаад 60 тн-оос хэтрэхгүй байна. Энэ тохиолдолд нөөцийн савны ачаалал нь цэнэглэгч машины даацаас нэг дахин их байна.

616. Нэг талбайн тусгаарлан хуваарилсан хэсгүүдэд тэсрэх материалыг турших ба устгах ажлыг гүйцэтгэж болно. Туршилт ба хаягдлын устгалыг нэгэн зэрэг гүйцэтгэхийг хориглоно.

617. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байрны төслийг боловсруулахдаа дахин боловсруулалтад орж байгаа материалын аюултай цахилгаанжилт үүсэхээс сэргийлэх арга хэмжээг тооцно.

618. Тэсрэх бодис бэлтгэх эсвэл дахин боловсруулах ажил явагдаж буй барилга байгууламжид радио идэвхт эх үүсвэрийг нь тэсрэлтэд тэсвэртэй чингэлэгт байрлуулсан, тэсрэлтийн хамгаалалтаараа тохирох маркийн радиоизотоптой багаж хэрэглэхийг зөвшөөрнө.

619. Бүх ангилалын тэсрэлтийн аюултай орчин, температурын бүх ангилал, группын бүсээс гарах хаалганы гадна талд ба хашааны хаалга, гарцны гадна тоос, чийгний хамгаалалттай цахилгаан тоноглол тавьж болно.

620. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байранд төрөл бүрийн утасгүй мэдрэгчүүд байрлуулахыг зөвшөөрнө. Энэ тохиолдолд хоёрдогч төхөөрөмжийг агаарт нь тэсрэх бодисын агууламжгүй байранд байрлуулах ба түүнийг мэдрэгчүүдтэй оч үүсгэх аюулгүй хэлхээгээр холбоно.

621. Дэлгэц, камерын систем, шингэний хавхлагын цахилгаан соронзон хөдөлгүүр, гал унтраах автомат системийн блок болон бусад гүйдэл хүлээн авагч хөдөлгөөнт төхөөрөмжүүд, мөн хөдөлгөөнгүй гүйдэл хүлээн авагчийн хэсгийн хэлхээг холбоход резинен эсвэл пластик бүрээстэй (эсвэл шлангтай) бүх ангилалын тэсрэлтийн

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага аюултай орчинд ашиглах зориулалтын уян зэс голтой кабель хэрэглэж болно. Механик үйлдлээр кабелийг гэмтээж болзошгүй хэсэгт түүнийг төмөр хоолой дотор байрлуулах, булан төмрөөр хаах болон бусад ийм төрлийн хамгаалалт хийнэ.

Оч үүсгэх аюулгүй хэлхээг хамгаалалтгүй кабелиар хийж болно.

622. Исэлдүүлэгч бодис болон тэдгээрийн уусмалтай үйл ажиллагаа явагддаг үйлдвэрийн барилгад импульсийн болон командын зэс хоолой ашиглахыг хориглоно. Мөн цайран хамгаалалттай, хар тугалган гадарга нь ил гарсан кабель хэрэглэхийг хориглоно.

Исэлдүүлэгч уусмал бэлтгэх процессыг автоматаар хянах түвшин хэмжигч, температур хэмжигчээр болон үйл ажиллагаанд ямар нэгэн алдаа үүсвэл дохио өгөх дохиоллын автомат системээр тоноглоно.

623. Бүх ангиллын тэсрэлтийн аюултай бүсэд, хэрэв орчин нөхцөл нь пластмасс материалыг гэмтээхгүйгээр бол пластмасс импульсийн хоолой хэрэглэж болно.

624. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх орчинд тэсрэлтийн болон галын аюултай бүтээгдэхүүн зөөж тээвэрлэх төхөөрөмж, өргөгч, тээвэрлэгч машинуудыг тэсрэлтээс хамгаалах зориулалтаар тоногдсон байна.

625. Бүх ангиллын тэсрэлтийн аюултай бүсэд байрлах машин механизмыг хөдөлгөөнд оруулах цахилгаан хөдөлгүүрийг аюултай бүсийн гадна байрлуулж, ханаар нэвтэрсэн хөдөлгүүрийн голд сальникан нягтруулга хийсэн бол тэсрэлтийн хамгаалалтгүй байхыг зөвшөөрнө.

626. Тэсрэлтийн болон галын аюултай үйлдвэрийн байр, түүний гадна орчинд ажил гүйцэтгэдэг тээвэрлэх төхөөрөмж, ачаа өргөгч болон тээврийн хэрэгслүүдэд дараахь зүйлсийг урьдчилан тооцсон байна. Үүнд:

а) цахилгаанаас болон бусад зүйлээс оч үүсгэдэггүй байх;

б) тосолгоо хийгддэг холбоосуудыг битүүмжилж, тэдгээрт ачиж тээж буй бүтээгдэхүүн орохоос хамгаалсан байх;

в) ачиж тээж буй бүтээгдэхүүний үлдэгдэл нь хөдөлгөөн багатай хэсэгт нь удаан хэвтэх, хуримтлагдах, бүрхүүл үүсэх, завсарт хавчуулагдахаас хамгаалах;

г) машин тоног төхөөрөмжийг үйлдвэрлэхдээ тэдгээрийн хийц, материал нь технологийн процессын онцлог, техникийн аюулгүй байдлын шаардлага, тээвэрлэх бүтээгдэхүүний аюултай үйлчлэлээс хамгаалахаар тооцсон байх.

627. Галын болон тэсрэлтийн аюултай бодис тээвэрлэх дамжуурга (туузан, гинжин, шурган) нь хий эргэх, татах хөтлөх анги тасрах, шураг чигжрэх зэрэг эвдрэл, гэмтэл, саатал гарсан үед зогсоох хамгаалалтын төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

628. Галын болон тэсрэлтийн аюултай бодис тээвэрлэх дамжуургын замын налуу эсвэл босоо хэсэгт дамжуургын татах хөтлөх анги болон тээвэрлэж буй ачааг өөрөө хөдөлгөөнд орохоос хамгаалах төхөөрөмжтэй байна.

629. Тэсрэх бодисыг нэг барилгаас нөгөөд дамжуургаар шилжүүлэхдээ тэдгээр бүтээгдэхүүнийг хэсэг хэсгээр (ширхэгээр) нь нэг барилгаас нөгөөд тэсрэлт дамжихгүй байх зайнд байрлуулна.

630. Тэсрэх бодисыг нэг барилгаас нөгөөд шаталт, тэсрэлт зогсоох хамгаалах тоноглол бүхий хийн төхөөрөмж ашиглан тээвэрлэж болно. Хадгалах байр болон бусад барилгын хооронд хийн төхөөрөмжөөр тэсрэх бодисыг тээвэрлэхийг хориглоно.

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага  
631. Тэсрэлтийн болон галын аюултай бүтээгдэхүүнийг шилжүүлэн зөөхөд ашигладаг өргөгч машин механизмын хөдөлгөөнийг удирдах удирдлага нь газарт байрлана.

632. Үйлдвэрлэлийн бүсэд байрлах төмөр зам нь уурхайн ерөнхий шугамаас цахилгааны тусгаарлалттай байна.

Тэсрэх бодисыг үйлдвэрээс мөргөцөгт хүргэхэд энэ зорилгоор тусгайлан тоноглогдсон уурхайн тээврийн хэрэгслийг ашиглана.

Тэсрэх бодисын суурин үйлдвэрээс доод түвшинд тэсрэх бодисыг хүргэхэд зориулан тоногдсон цооногийн тусламжтайгаар буулгаж болно. Буулгахдаа доод түвшинд байрлах, тэсрэх бодисыг задгайгаар тээвэрлэх эсвэл хадгалах тусгайлан тоноглогдсон бункерт эсвэл вагонд (цэнэглэх-тээвэрлэх машинд) ачаална.

Доод түвшинд байрлах буулгах байрыг хэсгийн тэсрэх бодис хадгалах, түгээх камерын шаардлагын дагуу тоногдсон байна.

Технологийн процессын явцад тэсрэлтийн аюултай бодисын тоос, уур ялгардаг тэсрэлтийн аюултай барилга байгууламжид ашиглах зориулалтын тээврийн хэрэгслийн (туузан дамжуулагч, транспортер, элеватор) механик эд ангиуд нь оч үүсгэдэггүй байна.

633. Ачаа тээвэрлэх үеийн хөдөлгөөний хурд, өсгөх (бууруулах) хурдатгал нь үйлдвэрлэлийн технологийн процессын удирдамжид зааснаас хэтрэхгүй байна. Хэрэв эдгээр үзүүлэлтийг заагаагүй бол тухайн өргөх, тээвэрлэх төхөөрөмжийн техникийн өгөгдлийг баримтална.

634. Химийн бодисыг үйлдвэрлэгчийн ашиглалтын зааврын дагуу хадгална.

635. Шуудайтай (зөөлөн чингэлэгтэй) аммиакийн, натрийн болон кальцийн шүүг исэлдүүлэгчийн нэг агуулахад хамтад нь хадгалж болох ба дэр тавиур дээр өрж нэг нэг тасалгаанд тус тусад нь эгнээгээр буюу тусдаа тасалгаануудад хадгална.

636. Эгнээ хооронд тоног төхөөрөмж явах зай 1.3 метрээс, эгнээ хоорондуур хүн явах зай 1 метрээс, тоног төхөөрөмж явах гол зам 2 метрээс багагүй байна.

637. Шуудай (зөөлөн чингэлэг)-г нуруулдаж хураасан эгнээний өндөр 2.6 метрээс, өргөн 5 метрээс ихгүй байна.

638. Мөхлөгт аммиакийн шүүг бункер, цамхагт агуулахад задгайгаар, хатуу хучлагатай задгай талбайд бүх төрлийн чингэлэгтэй хадгалж болно. Агуулах ба талбайг зориулалтын ачих, буулгах механизмаар тоногдсон байна.

639. Исэлдүүлэгч бодис хадгалах байр нь татах яндантай байна.

640. Аммиакийн натрийн болон кальцийн шүүг бункер болон ёроолоороо буулгагчтай хадгалах савнаас бусад шаландаа гүнзгийрүүлэн ухсан хонхор, сувагтай тасалгаанд задгайгаар хадгалахыг хориглоно. Агуулах нь хуурай байх ба дээвэр, шалны хэсгээр чийг орохоос хамгаалагдсан байна. Шүүний агуулахыг жилд нэгээс доошгүй удаа цэвэрлэх ба шаардалагатай бол шал, хананы завсар зайг битүүлж засварлана.

641. Аммиакийн натрийн болон кальцийн шүү хадгалах агуулах нь цаг тутмын агаарын солилцоо хангах ердийн байгалийн агааржуулалттай байна.

642. 200 м2 болон түүнээс их талбай бүхий аммиакийн натрийн болон кальцийн шүү хадгалах агуулахыг галын дохиоллын автомат системээр тоноглоно. Шүүний агуулахад ил гал гаргахыг хориглоно.



Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага

643. Аммиакийн шүүг задгайгаар хадгалах бункер, цамхагт агуулахын дамжуулан тээвэрлэх төхөөрөмжийн дээд гүүр (талбай) нь захаараа 0.14 метрээс багагүй өндөр битүү хашлагатай, битүү шалтай байна.

644. Шүүг хадгалах явцад байнгын хяналтын системтэй байх ба задралын шинж тэмдэг буюу халалт, азотын ислийн эсвэл аммиакийн онцлог хүчтэй үнэр гарч байгаа эсэх зэргийг тогтмол шалгана.

645. Задгай шүүтэй агуулахад дотоод шаталтын хөдөлгүүртэй сэрээт ачигч, авто тээврийн хэрэгсэл оруулахыг хориглоно.

646. Шүүтэй ажиллах тоног төхөөрөмжийн тосолгооны цэг, хэсгүүд хамгаалалттай байх ба тос, түлшээр шүү болон шүүний уусмалыг бохирдуулахгүй байхаар хийгдсэн байна. Санамсаргүй тохиолдлоор асгарсан сэрээт ачигчийн аккумуляторын шингэн хүхрийн хүчлээр бохирдсон аммиакийн шүүг агуулахаас яаралтай гаргах ба шүү асгарсан газрыг цэвэрлэж усаар угаана.

647. Дагтаршиж хатуурсан шүүг тэсэлж сийрэгжүүлэхийг хатуу хориглоно.

648. Карбамидыг шуудайтай болон контейнерт хадгалахыг зөвшөөрнө.

Карбамид, полиакриламид, карбоксиметилцеллюлозыг тус тусын поддон дээр, тус тусад нь эгнээ болгон хамт нэг агуулахад хадгалж болно.

649. Тэсрэх бодисын үйлдвэрийн бүсэд аюулгүйн зайг тооцохдоо аммиакийн шүүг оролцуулахгүй.

650. Шатамхай металлын нунтагийн агуулахыг үрэлт болон цохилтод оч үүсгэдэггүй, шатамхай бус материалаар хийнэ. Шатамхай металлын нунтагийн агуулах дор зорь хийх, шаланд хонхор нүх гаргахыг хориглоно.

651. Шатамхай металлын агуулах нь хур тунадас, хөрсний ус нэвтрэх болон хураасан савлагаатай металл дээр нарны шууд тусгал тусахаас хамгаалсан байна.

Зуны улиралд гадна агаарын температур өндөр (35°C, түүнээс их) байх үед агуулахыг өглөө, оройн цагаар заавал агааржуулна. Цаг агаарын хуурай нөхцөлд, агуулахын доторх агаарын чийгшил нь гаднах агаарын чийгшилээс харьцангуй их үед агуулахыг агааржуулна.

652. Агуулахад зөвхөн ачиж буулгах ажлыг гүйцэтгэх бөгөөд савлагаатай металл (хөнгөн цагааны нунтаг)-ыг суллах, дамжуулж савлах болон гал гаргах, бусад ажил гүйцэтгэхийг хориглоно.

653. Натрийн нитритийг тусдаа агуулахад дэр тавиур дээр, шуудайтай хадгална.

Натрийн нитритийг шүү болон бусад материалтай хамт хадгалахыг хориглоно.

654. Гал унтраах автомат систем нь заавал гар унтраалгатай байна. Гал унтраах автомат систем ажиллах үед үйлдвэрт ажиллаж байгаа ажилчид, технологийн процессыг зайнаас удирдах хэсэгт болон галын хэсэгт мэдээлэх дохио ажиллана.

Технологийн процессыг зайнаас удирдах үед гал унтраах систем автоматаар ажиллах буюу зайнаас удирдах хяналтын самбараас ажиллуулна.

Гал унтраах систем ажиллах үед технологийн тоног төхөөрөмж болон бусад цахилгаан төхөөрөмжийг автоматаар унтраах шийдлийг үйлдвэрлэлийн технологийн процессын удирдамж боловсруулагч тодорхойлсон байна.

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага

655. Агаар сэлгэлтийн сорох хоолой огцом эргэлтгүй, алгуур, шулуун хэлбэртэй байна. Агаар сэлгэлтийн хоолой нь сорох тал руугаа налуу байх ба тоос буухыг багасгах зорилгоор хэвтээ хэсгийн урт нь бага, мөн хуримтлагдсан тоосыг цэвэрлэх зориулалтын нээгдэж хаагддаг цонх, нээлхийтэй байна. Нээлхийний таглааны эд ангийг үрэлт цохилтоос оч үүсгэдэггүй материалаар хийнэ.

656. Тоос барих төхөөрөмжийн агааржуулалтын системийн элементүүдийг шатамхай бус, тоостой агаарт агуулагдах тэсрэх бодис ба түүний бүрэлдэхүүн хэсгүүдтэй химийн урвалд ордоггүй материалаар хийнэ.

657. Агаар сэлгэгчийн сувгийн агаарын хурдыг түүнд тоос суулгахгүй байхаар тооцно, гэхдээ 10 м/сек-ээс багагүй байна.

658. Агаар сэлгэлтийн төхөөрөмжөөс гадагш хаягдах тэсрэлтийн болон галын аюултай тоос агуулсан агаарыг зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хүртэл цэвэрлэнэ.

659. Агааржуулалтын системд тэсрэмтгий бодисын тоос хуримтлагдах магадлалтай хэсэг бүрээс бие даасан хавхлага хийнэ. Тусгаарлагдсан өрөөнд байрлах исэлдүүлэгчийн болон шатамхай металлын тоос сорох янданг агааржуулалтын нэгдсэн системд холбохыг хориглоно.

660. Агааржуулалтын нэгдсэн системийн сорох болон тэсрэх бодисын тоос ихээр ялгардаг өрөөний сорох системийн сэнс, шүүлтүүр, хаалт зэрэгт тэсрэлтийн хамгаалалттай агааржуулалтын төхөөрөмж ашиглана.

661. Тэсрэх бодис болон түүний бүрэлдэхүүн хэсгийн тоос ялгардаг технологийн процесс явагдах үйлдвэрийн өрөөний агаар сэлгэлтийг агаар сэлгэх төхөөрөмжийн ажиллагаа зогссон үед түүнд тэсрэлтийн аюултай тоос нэвтрэхгүй байхаар хаалт хийсэн нөхцөлд ердийн агаар сэлгэлтээр шийдэж болно.

662. Галын болон тэсрэлтийн аюултай үйлдвэрлэлийн процесс явагддаг барилгын агааржуулалтын төхөөрөмжийг нэг барилгаас нөгөөд гал дамжуулахгүй байхаар хийнэ.

663. Тэсрэлтийн аюултай барилга нь байгалийн агаар сэлгэлттэй бол цагт нэгээс доошгүй удаа агаар сэлгэлт хийх нөхцөлөөр хангагдсан байна.

664. Үйлдвэрлэлийн хэрэгцээний дулаан хангамжийн эх үүсвэр, халаалт, агаар сэлгэлт зэргийг өөрийн халаалтын уурын зуух, эсвэл цахилгааны эх үүсвэрээр хангаж болно. Хэрэв зуухнаас 135°C-ээс дээш температуртай уур, 100°C-ээс дээш температуртай ус нийлүүлдэг бол объект, барилга бүрт температур даралтыг шаардлагатай хэмжээнд бариулах дулааны зангилаатай байна.

### **Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодис бэлтгэх байрны ашиглалтын шаардлага. Техникийн болон технологийн баримт бичгүүд**

665. Тэсрэх бодисын үйлдвэрийн технологийн процессын удирдамжид дараахь баримт бичгүүд багтана. Үүнд:

а) уг удирдамжийг боловсруулахад ашигласан баримт бичгийн жагсаалт;

б) үйлдвэрлэж (бэлтгэж) байгаа тэсрэх бодис, түүхий эд, ба туслах материал, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн процессийн явцад үүсэх шатамхай хий ба химийн бүтээгдэхүүний шинж чанар, тэдгээрийн хоруу чанар (зөвшөөрөгдөх дээд хэмжээг заах), тэсрэлтийн болон галын аюултай шинж чанар, тэдгээртэй харьцах дүрэм, заавар;

в) үйлдвэрлэлд ашиглаж буй бодисын цахилгааны (хувийн цахилгаан

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага эсэргүүцэл) ба цахилгаан статик цэнэгт мэдрэмтгий шинжийн (дөл авалцах хамгийн бага энерги) үзүүлэлтүүд, статик цахилгаанжилтаас хамгаалах хэрэгслийн тодорхойлолт;

г) технологийн горимоор ажиллах дарааллын дагуу бичсэн технологийн процессын тайлбар, схемүүд, тэдгээрийг хянах хэмжих хэрэгсэл, дээж авах журам, хугацаа, хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүнийг хадгалах болон тээвэрлэх шаардлага;

д) технологийн процессын удирдлага ба хяналтын схем;

е) түүхий эд материалыг үйлдвэрлэлд оруулах зөвшөөрөл (оролтын хяналт);

ё) технологийн үндсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн товч тодорхойлолт;

з) тоног төхөөрөмжийг ажилд бэлтгэх дараалал;

ж) тоног төхөөрөмжийн болзошгүй гэмтэл ба тэдгээрийг засч залруулах арга хэмжээ;

и) тоног төхөөрөмжийг цэвэрлэх, угаах дараалал;

к) гологдлын төрлүүд, тэдгээрийг засах болон урьдчилан сэргийлэх аргууд;

л) үйлдвэрлэлийн хаягдлыг дахин ашиглах, устгах журам;

м) хаягдал ус болон хийн хаягдлыг цэвэрлэх, хоргүйжүүлэх арга, хэрэгсэл;

н) үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны шаардлага, галын аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шаардлага.

666. Технологийн процессын удирдамж, түүний өөрчлөлтийг төслийн баримт бичиг, хэрэглэх тоног төхөөрөмжийн ашиглалтын зааврыг үндэслэн тэсрэх бодисын үйлдвэрийг хариуцагч байгууллага өөрөө боловсруулна. Технологийн процессын удирдамж нь тухайн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийн үндсэн хэсэг байна.

Үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг үндэслэн боловсруулсан үйлдвэрийн үйл ажиллагааны технологийн горим, түүний өөрчлөлтийг ашиглагч байгууллагын техникийн хариуцлагатай удирдагч батална.

Батлагдсан үйлдвэрийн үйл ажиллагааны технологийн горим нь байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх баримт бичиг болно.

667. Технологийн горимд 5 жил тутамд хяналт хийнэ. Хяналтын удирдамжийг ашиглагч байгууллагын техникийн хариуцлагатай удирдагч батална.

668. Ашиглагч байгууллагын техникийн хариуцлагатай удирдагчийн зөвшөөрлөөр үйлдвэрийн технологийн горимын баримт бичигт өөрчлөлт оруулна.

669. Тэсрэх бодисын үйлдвэрлэлийн бүтцийн нэгж хэсгийн технологийн болон засварын ажил гүйцэтгэгч ажилтнуудын ажлын байр бүрт аюулгүй ажиллагааны заавартай байна.

670. Тухайн ажлын байранд гүйцэтгэх ажил өөрчлөгдөх бүр аюулгүй ажиллагааны зааврыг хянаж, өөрчилнө.

671. Тэсрэлтийн болон галын аюултай байранд ажиллах ажилчдын тоог технологийн

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага горимд заасан байна.

672. Технологийн тоног төхөөрөмжийг ажиллуулаагүй үед зааврын дагуу тэдгээрээс тэсрэх бодисыг цэвэрлэх ба цахилгааны эх үүсвэрээс салгаж, үйлдвэрийн хаалгыг хааж цоожлон, лацдаж харуулд хүлээлгэж өгнө. Хэрэв зарим тоног төхөөрөмжийг ажлын нөхцөлд үлдээх шаардлагатай бол байнгын хяналтад байлгана.

673. Ажлын ээлжийн төгсгөлд үйлдвэрлэлийн хаягдлыг (бохирдсон түүхий эд, асгарсан бодис) үйлдвэрийн байрнаас гаргаж, хог хаягдлын цэгт түр хадгалах эсвэл устгалд оруулна.

Хаягдлыг устгах давтамжийг технологийн горимд тусгасан байна. Хаягдлыг цуглуулах сав нь бүтээгдэхүүний сав баглаа боодлоос ялгагдах тэмдэгтэй байна. Савлах цэгийг тэмдэгжүүлсэн байна. Хоорондоо урвалд орох бодисын хаягдлыг нэг саванд хамт хийхийг хориглоно.

674. Үйлдвэрийн байранд тухайн үйлдвэрлэлд хэрэглэгддэггүй багаж хэрэгсэл, материал хадгалахыг хориглоно.

675. Тоног төхөөрөмж, барилгын хана, агааржуулалтын хоолой, ялангуяа тоног төхөөрөмжийн доргилт, цохилттой хэсэгт, шалан дээр, халуун гадаргуутай тоног төхөөрөмж дээр бүтээгдэхүүний тоос болон исэлдүүлэгч уусмалын тоосонцорын хуримтлал үүсгэхгүй байна. Тоос болон уусмалыг ажлын үед тогтмол цэвэрлэнэ. Үйлдвэрийн байр, тоног төхөөрөмжийг тоос, уусмал, бүтээгдэхүүний үлдэгдлээс цэвэрлэх цэвэрлэгээний хугацаа болон аргыг технологийн баримт бичиг, горимд тусгасан байна.

676. Тэсрэх бодисын үйлдвэрлэлийн үед ашиглах ажлын ширээний тавцан гөлгөр гадаргуутай, зай завсаргүй, ирмэгийн хашлагатай, илүү гарч цухуйсан оворгүй, цахилгаан дамжуулах материалаар бүрсэн, газардуулгатай байна.

677. Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодис бэлтгэх байранд өдөөх, тэслэх хэрэгсэл, галт зэвсэг, галын эх үүсвэр (шүдэнз, асаагуур) оруулахыг хориглоно. Тэсрэлтийн аюултай байранд цахилгаанаар халаагч хэрэгсэл ашиглахыг хориглоно.

678. Ажиллагаагүй болсон бүх төрлийн аппарат, тоног төхөөрөмж, холбоос деталь, багаж хэрэгсэл, тэсрэх бодистой харьцаж байсан хэрэгслүүдийг засварлах эсвэл устгахын өмнө бохирдлоос маш сайн цэвэрлэж, угаах ба шаардлагатай бол шатааж устгана. Цэвэрлэгээ хийсэн талаар акт үйлдэж баримтжуулна.

### **Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх тоног төхөөрөмжид тавих шаардлага**

679. Галын болон тэсрэлтийн аюултай үйлдвэрийн бүх тоног төхөөрөмжийг газардуулсан байна. Газардуулгын үзлэг шалгалт, туршилтыг цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын зааварт (дүрэмд) тодорхойлсон хугацаанд хийнэ.

680. Хөндлөн огтлол нь 6 мм-ээс багагүй дамжуулагч утсаар хийсэн газардуулагчийг цэнэглэгч машинаас газардуулагч төхөөрөмжид боолтоор холбосны дараа цэнэглэгч машинд тэсрэх бодис (хольцуудыг) ачаална. Газардуулагчийн утас, холбогч гадаргууг зэврэхээс хамгаалсан байна.

681. Тоног төхөөрөмжийн бүтэц хэсгүүд, ялангуяа үрэлттэй хэсгүүдийн хооронд бүтээгдэхүүн орох зай завсаргүй хийгдсэн байна.

682. Тоног төхөөрөмжийн эд ангиуд, фланц, люк зэргийг холбох жийргэвчүүдийг тухайн ашиглагдаж буй химийн бодист тэсвэртэй, уян материалаар хийсэн байна.

683. Тэсрэх бодисын үйлдвэрийн тоног төхөөрөмж нь тэсрэх бодис болон исэлдүүлэгч

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага (исэлдүүлэгчийн уусмал) дээр тос, тосолгооны материал дусах, гоожих боломжгүйгээр хийгдсэн байна.

684. Бүх тоног төхөөрөмж, савны дотор үзлэг, цэвэрлэгээ хийх боломжоор хангагдсан байна.

685. Удаан хугацаанд хадгалахад задрал үүсдэг бодис бэлтгэдэг тоног төхөөрөмж, мөн тэдгээр бодисыг дамжуулах шугам хоолой зэргийн аль нэг хэсэгт бүтээгдэхүүний үлдэгдэл, зогсонги байдал үүсэх боломжгүйгээр хийгдсэн, гадаргуу нь гөлгөр, наалдсан бодисоос хялбар цэвэрлэгддэг байна. Дулаан тусгаарлах материал нь галд тэсвэртэй, харьцаж байгаа химийн бодисуудад химийн идэвхгүй шинж чанартай байна. Тоног төхөөрөмжийн хийц хэсгүүд нь тэсрэх бодис болон түүний хольц хэсгүүд, хагас боловсруулсан бүтээгдэхүүнтэй харилцан үйлчлэлд ордоггүй материалаар хийгдсэн байна. Исэлдүүлэгчтэй харьцах боломжтой тоног төхөөрөмжүүд болон тэдгээрийн деталь хэсгийг зэс, цайр, хар тугалга, тэдгээрийн хайлшаар үйлдвэрлэхийг хориглоно. Тоног төхөөрөмжийн зарим хэсэг, тухайлбал галын болон тэсрэлтийн аюултай бодистой харьцдаг хэсгүүдийг цохилт болон үрэлтэд оч хаяхгүй материалаар хийнэ.

686. Тэсрэх бодистой тоног төхөөрөмжийн дотор эргэх гол байрладаг бол, тэрхүү голын холхивчуудыг тоног төхөөрөмжийн гадна талд байрлуулсан байна. Холхивчийг тэсрэх бодисоос тусгаарлаж байгаа хана, холхивч хоёрын хоорондын зай 40 мм-ээс багагүй байна.

687. Алсын зайнаас удирдлагатай тоног төхөөрөмж нь түүнийг ажлын байрнаас ажиллуулах, унтраахад зориулсан давхар удирдлагатай байна.

688. Ашиглалтад оруулж (хүлээн авч) байгаа тоног төхөөрөмж, хянах хэмжих хэрэгсэлүүд, аппаратуудыг тэсрэх материалтай харьцан ажиллах зөвшөөрөл олгохын өмнө хоосон байдлаар, орлуулах загвар ашиглан шалгаж, ажиллахыг зөвшөөрөх тухай акт үйлдэнэ.

### **Статик цахилгаанаас хамгаалах аргууд**

689. Шигших, тээрэмдэх, бутлах, холих аппаратуудаас бүтээгдэхүүн ачих, буулгах, хийн болон вакуум шахуургаар тээвэрлэх зэрэг процессын үед статик цахилгаан цэнэг үүсэх болон хуримтлагдах өндөр магадлалтай. Технологийн процессын удирдамж болон технологийн процессын заавар боловсруулагч нь үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрөл бүрээр статик цахилгааны аюулгүй байдлыг хангах технологийн процессын зөвшөөрөгдөх параметруудийг тогтоож баримт бичигт тусгасан байна.

690. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч цахилгаан статик цэнэг үүсэх аюулаас сэргийлэхийн тулд дараахь арга хэмжээнүүдийг урьдчилан тооцсон байна. Үүнд:

- а) цахилгаан дамжуулах тоног төхөөрөмж, хэлхээнд газардуулга хийх;
- б) саармагжуулагч хэрэглэх;
- в) антистатик ремень (тууз) хэрэглэх;
- г) хоорондоо хүрэлцэх эерэг, сөрөг цэнэгээр цахилгаанждаг материалуудыг хослуулж сонгох;
- д) орчны агаарыг чийгшүүлэх;
- е) тоног төхөөрөмжид цахилгаан дамжуулагч материал ашиглах;

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага  
ё) ажлын тусгай хувцас хэрэглэх.

691. Статик цахилгаан цэнэг үүсэх идэвхжилийг багасгахын тулд дараахь шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

а) агаарт дэгдсэн шингэн болон хатуу тоосонцорыг цэвэрлэх, технологийн хувьд боломжтой бол шингэнийг уур-хий тоосонцорын хатуу болон шингэн хольцын бохирдлоос цэвэрлэх;

б) шатамхай орчны агууламжийг тэсрэлтийн аюултай хязгаарын үзүүлэлтэд хүргэхгүй байх;

в) бодисыг цацах, нунтаглах, тоосруулах зэрэг технологийн процесст шаардагдаагүй үйлдлийг хориглох;

г) шугам хоолой, шланг, форсунк, хошуунаас гарах уур, хий конденсацлагдахгүй, талсжихгүй байх;

д) технологийн процессоор зөвшөөрөгдсөн бол агаарын харьцангуй чийгшлийг 65%-иас багагүй байлгах;

е) тээвэрлэлт, боловсруулалтын хурдыг бууруулж, тоос-уур хийн холимог ба шингэний урсгалын хуйлралтыг багасгах.

692. Статик цахилгаан цэнэг үүсч, хуримтлагдах боломжтой технологийн бүх тоног төхөөрөмж /шингэн, хий, уур, хуурай материалыг дамжуулах, боловсруулахад зориулагдсан аппаратууд, емкость савнууд, шугам хоолой, ажлын ширээ тавцангийн гадаргуу, савлах болон юүлэх төхөөрөмж зэрэг/-ийг металл /төмөр/ эсвэл цахилгаан дамжуулах материалаар хийж, газардуулсан байна.

693. Бүтээгдэхүүнийг нунтаглах, холих, цацах, дамжуулах процесс явагддаг аппаратууд, емкость савнууд, холбоосууд, шугам хоолойнууд, мөн тусдаа байрлаж үндсэн системийн тоног төхөөрөмжтэй шугам хоолойгоор холбогдсон машин, төхөөрөмжийг тэдгээртэй холбогдсон байгууламжууд ерөнхий газардуулгын хэлхээнд холбогдсон эсэхээс үл хамааран барилгын дотоод газардуулгын хүрээнд тус тусад нь салаалж газардуулна.

Хэд хэдэн тоног төхөөрөмж, аппарат, шугам хоолойг цуваа холбоосоор газардуулахыг хориглоно.

Статик цахилгаанаас хамгаалах газардуулгыг цахилгаан тоног төхөөрөмжийн газардуулгатай нэгтгэн холбохыг зөвшөөрнө.

Газардуулах холбоосууд, тэдгээрийг холбох аргыг техникийн баримт бичигт зааж өгнө. Үйлдвэрийн барилга бүрт газардуулгын схем зураг хийсэн байна.

694. Цахилгаан дамжуулах материалаар (метал биш) хийсэн тоног төхөөрөмжийн дотор гадаргууд хамгийн зайтай орших дурын цэгийн дотор газардуулгын хүрээтэй харьцуулсан газардуулгын эсэргүүцэл нь 106 Ом-оос ихгүй байна. Зөвхөн статик цахилгаанжилтаас хамгаалах зориулалтын газардуулгын төхөөрөмжийн эсэргүүцэл 100 Ом-оос ихгүй байна.

695. Газардуулгын холбоосууд болон газардуулгын хүрээ нь тэдгээрт үзлэг шалгалт хийх боломжтой ил байрлалтай байна. Ингэхдээ тэдгээрийн механик үйлчлэлд болон химийн бодисын нөлөөлөлд орохгүй байх нөхцөлийг хангасан байна.

696. Технологийн тоног төхөөрөмжийг статик цэнэгээс хамгаалах газардуулгын дамжуулагч утасны тоног төхөөрөмжид болон газардуулгын дотоод хүрээнд холбох

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага хэсгийг 15 мм өргөн хөндлөн улаан зураасаар тэмдэглэсэн байна.

697. Газардуулгын хүрээний элементүүдийг хооронд нь болон газардуулагчийг газардуулгын хүрээ ба газардуулж буй тоног төхөөрөмжид гагнаж холбоно. Гагнуур хийж холбох боломжгүй бол найдвартай болтон холбоосоор холбоно. Ингэхдээ газардуулагч утасны голын үзүүрт битүү цагираг гагнаж буюу давтаж холбосон байна. Болтон холбоосыг зэврэлтээс хамгаалсан байна.

698. Бие биенээсээ 0.1 метр хүртэл зайд зэрэгцээ байрлах дамжуулах хоолойнуудыг 20 метр тутамд хооронд нь тушиж холбоно. Дамжуулах шугам хоолойнууд хоорондоо болон төмөр шат, барилгын хийц хэсэгтэй 0.1 метрээс бага зайд огтлолцох бол тэдгээрийг мөн хооронд нь тушиж холбоно. Агааржуулалтын металл хоолойнуудыг 20 метр тутамд хөнгөн цагааны хайлшаар хийсэн 5 мм-ээс багагүй диаметртай дамжуулагч, 24 мм<sup>2</sup> -ээс багагүй хөндлөн огтлолтой лент ашиглан газардуулна.

699. Газардуулсан их биеээсээ хөндийрч гэмтэх боломжтой машин тоног төхөөрөмжийн эргэлдэх хөдөлгөөнтэй цахилгаанждаг эд анги нь газардуулга холбох зориулалтын цахилгаан гүйдэл баригч төхөөрөмжтэй байна. Бодисын цахилгаанжилт эрчимтэй явагддаг хэсэг бүхий төхөөрөмж болон доргиурт тоног төхөөрөмжийн хөдөлгөөнтэй хэлхээг 2-оос доошгүй цэгт газардуулна. Хуурай бүтээгдэхүүнийг шатах шингэний ууртай төхөөрөмжийн нээлхийрүү цаас, полиэтилен, полихлорвинил болон бусад цахилгаанжих төрлийн материалаар хийсэн уут, шуудайнаас шууд асгаж хийхийг хориглоно. Энэ тохиолдолд цахилгаан дамжуулдаг материалаар хийсэн, аль болох бага тоосжилт үүсгэдэг зориулалтын юүлэх төхөөрөмж ашиглана. Хуурай бодисоос дээж авах буюу технологийн үзүүлэлт хэмжихээр төхөөрөмжөөс дээж авахдаа дээж авагч багаж, төхөөрөмжийг заавал бодисын тоосжилт буусны дараа оруулна.

700. Үйлдвэрлэлийн нөхцөлд ашиглагч байгууллагын техникийн удирдагчийн баталсан хуваарийн дагуу жилд 2-оос доошгүй удаа цахилгаанжилтын үзүүлэлтийн хэмжилт хийнэ.

### **Тэсрэх бодисын үйлдвэрт тэсрэх материалыг хадгалах, бүртгэх үйл ажиллагаа**

701. Тэсрэх материалын үйлдвэрийн хог хаягдалтай харьцахдаа тэсрэх материалыг хадгалах болон бүртгэх журмыг нэгэн адил дагаж мөрдөнө.

702. Үйлдвэрлэсэн тэсрэх бодисын нийт хэмжээг түүнийг үйлдвэрлэхэд зарцуулагдсан бүрэлдэхүүн хэсгийн орцуудын хэмжээгээр тодорхойлно.

703. Тэсрэх бодис үйлдвэрлэх, бэлтгэх байранд холин цэнэглэгч машинд ачилт хийсний дараа түүний ачилт, буулгалтын нээлхийнүүдийг хааж лацадсан байна.

704. Шатамхай металл агуулаагүй тэсрэх бодис, эмульс ачсан холин цэнэглэгч машиныг харуул хамгаалалттай, тусгаарласан зориулалтын талбайд эсвэл цэнэглэгч машиныг ачих байранд 2 хоногоос хэтрэхгүй хугацаанд байлгаж болно. Цэнэглэгч машинд байх тэсрэх бодисын хэмжээг бүртгэж, машины ачих буулгах нээлхийг лацдах ба харин хадгалах байр нь энэхүү дүрмийн 673-ын шаардлагыг хангасан байна.

### **ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН АГУУЛАХ БАЙГУУЛАХ, АШИГЛАХАД ТАВИХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА**

705. Тэсрэх материалыг энэхүү дүрмийн шаардлагыг хангасан, зориулалтын байр, тасалгаанд хадгална. Тэсрэх материал хадгалах агуулах, байрыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран актаар ашиглалтад оруулна.

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага

706. Аюултай байдлын зэрэглэлийн ангиллаар ялгаатай тэсрэх материалыг тус тусад нь хадгална. Дор дурдсан тэсрэх материалыг нэг агуулахад хадгалж болно. Үүнд:

а) D ангиллын утаат болон C ангиллын утаагүй дарийг тэдгээрийн аль илүү мэдрэмтгий чанарт тавигдах шаардлагыг хангасны үндсэн дээр;

б) G ангиллын гал дамжуулах шижим болон дарийг асаах хэрэгсэл, дохионы, дарьт патрон, дохионы пуужинг B, C болон D ангиллын тэсрэх материалтай хамт;

в) D ангиллын цочир дамжуулах шижим, цочир дамжуулах туузыг B хамтатгах ангиллын ердийн тэслүүр, цахилгаан тэслүүр болон пиротехникийн релетэй хамт;

г) S ангиллын өдөөх хэрэгслийг B ангиллын өдөөх хэрэгсэлтэй хамт;

д) S ангиллын кумулятив цэнэгийг D ангиллын кумулятив цэнэгтэй хамт;

707. Байнгын болон түр, түгээх агуулахыг эзэмшигч байгууллага нь энэхүү дүрмийн Хавсралт 15-ын дагуу агуулахын паспорттай байна. Агуулахын паспортын нэг хувийг агуулахад хадгална.

708. Судалгааны болон сургалтын байгууллага нь ашиглах, хадгалахыг нь зөвшөөрсөн тэсрэх материалтай хамт (жишээ нь: нэг сейфэнд) шинээр бэлтгэсэн тэсрэх материалыг хамт хийж хадгалахыг хориглоно.

709. Агуулахад байгаа тэсрэх материалтай задалсан хайрцаг савыг таглаж, онгойлгосон уутны амыг боосон байна.

710. Тэсрэх материалтай агуулахыг цоожилж, дугаартай, нэг удаагийн лацаар лацадсан байна.

711. Тэсрэх материал хадгалах зориулалтаар газрын дээр нэг талбайд цогцоор байгуулсан агуулах, чингэлэг, болон туслах зориулалтын барилга байгууламжууд (бүхэлд нь тэсрэх материалын агуулах, агуулах-үйлдвэрийн цогцолбор гэх), далд уурхай дахь тэсрэх материал түгээх агуулах зэрэг нь тэсрэх материал хадгалах, үйлдвэрлэх, бэлтгэх бусад байрыг “Тэсрэх материалын агуулах, түүний зураг төсөл, агуулахын аюулгүйн бүс тогтоолгох, ашиглахад тавигдах шаардлага”-ын дагуу батлагдсан төслөөр байгуулж, тоноглон, энэхүү дүрмийн шаардлагын дагуу ашиглана. Харин далд уурхайн тэсрэх материал түгээх цэг нь паспорттай, төсөлгүй байж болно. (Энэ заалтыг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан)

712. Тэсрэх материалын агуулахыг байрлалын хувьд газрын дээрх (ил), хагас далдлагдсан, далдлагдсан, газрын доорх гэж ангилна. Газрын дээрх гэж агуулахын суурь нь газрын гадарга дээр ил байрласан, хагас далдлагдсан гэж газрын хөрсөнд суулгаж агуулахын дээврийн хормой нь газрын хөрснөөс доош суулгаж барьсан, далдлагдсан агуулах гэж агуулахын дээрх хөрсний зузаан газрын хөрснөөс доош 15 метрээс илүүгүй гүнтэй, газрын доорх гэж агуулахын дээрх хөрсний зузаан нь 15 метрээс их гүнд байрласан агуулахуудыг тус тус хэлнэ.

713. Агуулах нь ашиглалтын хугацаанаас хамааран байнгын, түр (3 жил хүртэл), богино хугацааны (1 жил хүртэл) байна. Түр агуулахыг комисс зөвшөөрсөн тохиолдолд дахин хугацааг нь сунган ашиглах боломжтой. Агуулахыг ашиглахгүй болсон талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

714. Тэсрэх материалын агуулахыг зориулалтаар нь төв болон түгээх гэж ангилна.

715. Улирлын чанартай болон хөдөлгөөнтэй ажилд зориулж тэсрэх материал, аммиакийн шүүг контейнерт хадгалж болно. Контейнерүүдийг тэсрэх материалын агуулахын хэсэг болгож, эсвэл тусад нь дан контейнерүүдээс бүрдсэн тэсрэх материалын агуулах байдлаар тоноглож болно. Контейнерүүд нь бүрэн бүтэн байх ба дугаарлагдсан, лацтай байна. Тэсэлгээний хэрэгслийг контейнерт хадгалахдаа



Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага тэдгээрийг агуулахад хадгалахад тавигдах шаардлагыг мөрдөж хадгална.

716. Аммиакийн шүүг тэсрэх материалын агуулахын тусгай байр, талбайд хадгална.

717. Тэсрэх материалын агуулахад хадгалж буй аммиакийн шүүнд бусад тэсрэх материалын нэгэн адил бүртгэл хөтөлнө. Тэсрэх материалын агуулахын паспортод аммиакийн шүүний хадгалалтыг тусгайлан заасан байна.

718. Агуулахад хадгалах болон тэсрэх бодис үйлдвэрлэх цэгт байгаа аммиакийн шүүг тэсрэх материалын агуулахын аюулгүйн бүсийн тооцоонд оруулж тооцохгүй.

719. Тэсрэх материалын агуулахын болон ачих, буулгах зориулалтын бункерүүдэд хадгалсан задгай аммиакийн шүүг 10 хоногоос илүү хугацаанд хөдөлгөөнгүй байлгаж болохгүй.

720. Далдлагдсан болон газрын доорх түгээх агуулах болон тэсрэх материал түр хадгалах малталтуудын багтаамжийг төслөөр тодорхойлно. Ингэхдээ нүүрсний болон занарын далд уурхай дахь түгээх агуулахын багтаамжийг тэсрэх материал түр хадгалах хонгил, хайрцгуудын хэмжээг оруулахгүйгээр тэсрэх бодисын 7 хоногийн, тэсэлгээний хэрэгслийн 15 хоногийн хэрэглээнээс хэтрэхгүйгээр тооцно. Хонгил агуулахад 2 тн-оос, хайрцагт агуулахад 400 кг-аас хэтрэхгүй тэсрэх бодис хадгална.

Далд малталт дахь хэсгийн түгээх агуулахад 2 тн-оос илүүгүй тэсрэх бодис, түүнд тохирсон тэсэлгээний хэрэгсэл, тусгай хэсгийн түгээх цэгт 1 тн-оос илүүгүй тэсрэх бодис, түүнд тохирсон тэсэлгээний хэрэгсэл хадгалж болно.

721. Судалгааны байгууллага, лаборатори, сургалтын байгууллага нь судалгааны зориулалтаар ашиглах тэсрэх материалыг сейфэнд хадгалж болно. Тэсрэх материалыг нэг байранд бие биенээсээ тэсрэлт дамжихгүй зайд байрлуулсан сейфэнд төрөл төрлөөр нь тусад нь хадгална. Нэг сейфэнд тэсрэх бодис 10 кг-аас, тэслүүр 500 ширхгээс, цочир дамжуулах болон гал дамжуулах шижим тус бүр 300 метрээс илүүгүй хэмжээтэй байна.

722. Агуулахаас тэсэлгээчинд тэсрэх материал тавьж олгох болон зарцуулагдаагүй тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, буудлагын аппаратыг тэднээс буцааж хүлээж авах байр нь 25 см-ээс багагүй зузаан шатдаггүй (бетон, тоосго г.м.) битүү ханатай, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлд зориулсан хоёр тусдаа тасалгаатай байх бөгөөд агуулахын хаалганаас 20 метрээс ойргүй зайд байрлана. Энэ байр нь тэсрэх материал тавьж олгох үүдний өрөөтэй байна.

Тэсрэх материал тавьж олгох байранд бүх төрлийн тэсрэх материалын хэмжээ 3000 кг-аас, тэслүүрийн тоо 10000 ширхэгээс илүүгүй байна. Тэслүүртэй хайрцгийг хананы дагуух тавиур дээр байрлуулна. Энэ байранд тэсрэх материал хадгалахыг хориглоно.

723. Төв агуулахаас тавьж олгох цочир дамжуулах шижимтэй галлагчийг тусгай байранд бэлтгэнэ.

724. Байнгын болон түр тэсрэх материалын агуулахаас тэсрэх материал тавьж олгох, зарцуулагдаагүй тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хүлээн авах ажиллагааг тусгай байр болон агуулахын үүдний тасалгаанд гүйцэтгэнэ. Энд детонатор тавьж олгох зөөлөвчлөн бүрсэн, эсвэл 3 мм-ээс нимгэнгүй, 105 Ом/м-оос ихгүй эсэргүүцэлтэй хагас дамжуулагч резинэн хавтангаар бүрсэн, тавцангийнхаа ирмэгт хөвөөтэй ширээ болон цочир дамжуулах шижим, гал дамжуулах шижим огтлох ширээтэй байна. Цахилгаан детонаторыг статик цахилгаанжилтын нөлөөнөөс хамгаалах зорилгоор ширээг газардуулсан бөгөөд түүний эсэргүүцэл нь 100 Ом-оос илүүгүй байна. Эдгээр байранд тэсрэх материал хадгалахыг хориглоно.

725. Тэсрэх материалын агуулахын тасалгаануудын шал зай завсаргүй, тэгшхэн, ханыг будсан байна. Тасалгаанууд нь агаар өөрөө орж, гарах агааржуулалтын сувагтай, цас, борооны ус орохоос хамгаалагдсан байна.

726. Тэсрэх материалын агуулахын тасалгаануудад тавиур, тавцантай байх ба хураасан тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хананаас 20 см, шалнаас 10 см-ээс багагүй өндөрт байрлуулна. Уут, шуудай, хайрцагтай тэсрэх бодисыг поддон, тавиур

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага дээр чөлөөтэй тоолох боломжтойгоор өрж хураана. Хураалтын өндөр 2 метрээс илүүгүй байна.

Поддон, тавиур болон шуудай байрлуулах зарчмыг агуулахын паспортод заасан байна. Ачих, буулгах механикжсан төхөөрөмж хэрэглэх тохиолдолд хураалтын өндөр 2.6 метрээс ихгүй, хураасан эгнээ, шуудайнуудын хооронд 1.3 метр, поддон, тавиурын хооронд 1 метрээс багагүй зайтай байна.

727. Уут, хайрцагтай тэсрэх материалыг давхарлаж хураахдаа үйлдвэрлэгчийн зааврыг баримтлана. Задалсан уут, хайрцагтай В, С ангиллын тэсрэх материалыг давхарлалгүй хураана. Ийм тэсрэх материалтай тавиурын дээд давхарын өндөр 1.7 метр, бусад материалынх 2 метрээс илүүгүй өндөртэй байна. Давхар тавцангийн хооронд байрлуулсан тэсрэх материалын уут хайрцагнаас дээд тавцан хүртэлх завсар 4 см-ээс багагүй байна. Тэсрэх материалыг тавиур дээр чөлөөтэй тоолох боломжтойгоор хураана. Тэсрэх материалтай хамт холбогдолгүй бусад зүйл шатамхай болон химийн идэвхитэй материал хадгалахыг хориглоно. Тавиурын төмөр хадаас боолтны толгойг суулгаж далдалсан байна. Тавиурын тавцангийн банзнуудын хоорондын зай 3 см-ээс илүүгүй байх бөгөөд, доод тавцангийнх завсаргүй байна. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор 6 дахь өгүүлбэрийг нэмсэн)

728. Агуулах дахь тэсрэх материалтай тавиур болон хураасан эгнээ бүрт тэсрэх материалын нэр, тоо хэмжээ, үйлдвэрлэсэн огноо, баталгаат хугацааг тэмдэглэсэн хуудастай мэдээлэх самбарыг шууд харагдахуйц газар байрлуулна.

729. Цахилгаан тэслүүр, цахилгаан асаах гуурс, дөллөгч болон тэдгээрийг агуулсан тэсрэх материалыг зөвхөн үйлдвэрлэгчийн, эсвэл зориулалтын сав баглаатай хадгална.

730. Асаах болон хяналтын (гал дамжуулах шижмийн хяналтын хэрчим) гуурсыг тэдгээрийг бэлтгэхэд зориулсан тусгай байранд бэлтгэнэ. Энэ байр нь тэсрэх бодис бэлтгэх байрнаас галд тэсвэртэй ханаар тусгаарлагдсан, галд тэсвэртэй будгаар өнгөлсөн дотортой байна. Далд уурхайд асаах гуурсыг зориулалтын хонгилд бэлтгэнэ.

Олон хүн асаах гуурс зэрэг бэлтгэх үед ширээ хүн бүрийг хооронд нь тусгаарлах модон таславчтай байна. Асаах болон хяналтын гуурс бэлтгэх, хадгалах байрны шал зөөлөн дэвсгэртэй байна. Бэлтгэсэн хяналтын гуурсыг дотор талыг нь зөөлөвчилсэн, металл болон металл бүрээстэй модон хайрцаг, шүүгээ, дайзанд хийж түгээх агуулахад хадгална. Хайрцаг, шүүгээ нь таглаа, хаалгатай байна.

731. Аммиакийн шүүнд суурилсан тэсрэх бодистой агуулахын температур 30°C-ээс ихгүй байна.

735. Газрын дээрх тэсрэх материалын байнгын агуулах нь дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

- үерээс хамгаалах, ус зайлуулах сувагтай байх;
- байнга цэвэрлэж зассан (авто зам, төмөр зам гэх мэт) замтай байх;
- тэсрэх материал хадгалах байр, агуулахыг байрлуулахдаа тэдгээрийн нэг бүрт чөлөөтэй хүрэх замтай байх нөхцөлийг хангасан байх;
- агуулах хоорондын, агуулах ба бусад барилга байгууламжийн хоорондын зай нь галын аюулгүй байдлын норм болон энэхүү дүрмийн IX бүлгийн шаардлагыг хангасан байх;
- агуулахын талбай нь хашаатай байхын зэрэгцээ хашаанаас гадагш 50 метрээс багагүй зайд хамгаалалтын хориотой бүс тогтоож, түүний хүрээгээр анхааруулах тэмдэг тавьсан байна.

736. Агуулахын талбайд (агуулахын хашаанд) дараахь барилга байгууламжууд байна.

- тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цөмлөх болон буудлагын төхөөрөмжийн агуулахууд;
- тэсрэх материалтай болон аммиакийн шүүтэй чингэлгүүд байрлуулсан

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага талбай;

-тэсрэх материал тавьж олгох байр;

-ачаа буулгах тавцан, тэсрэх материал ачих, буулгах, хадгалах зориулалтын байгууламж;

-мөхлөгт болон эмульсийн тэсрэх бодис бэлтгэх цэг, түүхий эдийг хадгалах байр (тусгаарласан хашаатай);

-үйлдвэрийн тэсрэх бодисыг механикжуулсан цэнэглэлтэнд бэлтгэх цэг, лаборатори;

-харуулын цамхаг, харуулын нохойн хонуур, гэрэлтүүлэг, камерын цамхаг; (Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)

-гал эсэргүүцэх хэрэгслийн самбар;

-шалган нэвтрүүлэх байр (хаалганы гадна талд); (Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмэлт орсон)

-аянгаас хамгаалах байгууламж.

737. Агуулах, үйлдвэрийн аюултай бүсийн хүрээнд дараахь барилга байгууламжууд байж болно. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)

-тэсрэх материал турших, устгах, сав баглаа шатаах талбай, харуулын байр;

-агуулахын ажилчдын захиргаа үйлчилгээний байр;

-механикжуулсан тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний байр;

-уурын зуух, газрын тосны бүтээгдэхүүн агуулах сав;

-усан хангамж, бохирын шугам хоолой, насосны станц;

-бууруулах трансформаторын дэд станц;

-сав баглааны сарай, саравч.

Тэсрэх материалын агуулахад хамааралгүй объектууд (барилга байгууламж, хүн ам оршин суух газар) нь энэхүү дүрмийн IX бүлгийн шаардлагын дагуу тооцож тогтоосон аюултай бүсийн гадна байрлана.

763. Түр агуулахын зориулалтаар тоногдсон төмөр чингэлэг болон тусгайлан барьсан байрыг ашиглаж болно. Эдгээр байрууд нь агааржуулалттай, бороо цас, халалтаас хамгаалагдсан байх ёстой.

764. Түр агуулах нь:

а) мод, бетон шалтай байж болно;

б) модон шал, хана, таазыг галд тэсвэртэй бодисоор өнгөлсөн байна;

в) 2 метрээс багагүй өндөртэй хашаатай байна;

г) усан сангүй байж болно;

д) хуурай батарейтай уурхайн гэрэл ашиглаж болно;

е) тамбургүй байж болно.

Түр агуулахад энэхүү дүрмийн 763, 764-д зааснаас бусад байнгын агуулахад тавих бүх шаардлагыг дагаж мөрдөнө.

765. Богино хугацаанд гүйцэтгэх тэсэлгээний ажилд ашиглах тэсрэх материалыг тэсэлгээний ажил хийх газрын ойролцоо газарт байрлах ашиглалтгүй барилга байшин, нүхэн байгууламж, төмөр чингэлэг, авто машин, чиргүүлд хадгалж болно.

766. Тэсрэх материалын богино хугацааны агуулах нь энэхүү дүрмийн 763, 764-д заасан шаардлагыг хангасан байна. Ингэхдээ аянга зайлуулагчтай, хадгалах байрны

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага гэрэлтүүлэгтэй, холбооны хэрэгсэлтэй, суваг (түймрээс хамгаалах зурвас)-тай байхыг шаардахгүй. Агуулахын хориотой бүсийн модыг унагаж цэвэрлэсэн байхыг шаардахгүй. Хашааг тэсрэх материал хадгалах байрны хананаас 20 метрээс ойргүй зайд байрлуулахыг зөвшөөрнө. Хашааны өндөр 2 метрээс намгүй байна. Харуулын байрыг хашаанаас 15 метрээс багагүй зайд байрлуулна.

Хориотой бүсийн өргөн 20 метрээс багагүй байна. Богино хугацааны агуулахын байрны модон ханыг гадна дотноос нь галд тэсвэртэй бодисоор өнгөлсөн, дээвэр тааз, шал нь шатдаггүй материалтай буюу мөн галд тэсвэртэй бодисоор өнгөлсөн байна.

768. Байршил нь тогтмол бус, хөдөлгөөнтэй ажилд хэрэглэх тэсрэх материалыг тусгайлан тоноглон автомашин, чиргүүлд (хөдөлгөөнт агуулах) хадгалж болно. (Энэ заалтын зарим хэсгийг Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолоор хассан)

769. Хөдөлгөөнт агуулах нь автомашин, чиргүүл дээр салахгүйгээр бат бөх бэхэлсэн битүү бүхээг байна.

Тэсрэх материалын хөдөлгөөнт агуулахаар тоноглох авто тээврийн хэрэгсэл нь тэсрэх материал тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавих шаардлагыг хангасан байна.

770. Судалгаа, сургалтын байгууллагад тэсрэх материалыг сейфтэй тасалгаанд буюу агуулахын тасалгаанд хадгална. Тасалгаа нь шатдаггүй хана, таазтай, зэргэлдээ өрөөнөөсөө 25 см-ээс багагүй зузаантай бетонон буюу тоосгон ханаар тусгаарлагдах бөгөөд зэргэлдээ өрөөнд нь хүн тогтмол байрлах ажлын байр байлгахыг хориглоно. Тасалгааны хаалгыг 45 минутаас багагүй хугацаанд галд тэсвэрлэх материалаар хийсэн байна.

Тэсэлгээний хэрэгсэл хадгалах сейфийг зөөлөн материалаар доторлосон, газардуулсан байх бөгөөд тэсрэх бодистой сейфээс 2 метрээс ойргүй зайд байрлуулна. Тасалгааг хамгаалалтын болон галын дохиоллоор тоноглоно.

771. Далд уурхайд тэсрэх материалыг зориудаар тоноглон малталт болон камер, хайрцагуудад хадгална. Тэдгээрийн аль нэгэнд нь тэсрэлт үүсэхэд бусдад нь тэсрэлт дамжихгүй байхаар байрлалтай байна.

Далд уурхайн газрын доорх тэсрэх материалын агуулах нь тэсрэх материал хадгалах камер, хайрцаг байрлуулсан малталт, түүн рүү орох, гарах хонгил, туслах камеруудаас бүрдэнэ. Туслах камерт:

-цахилгаан детонатор шалгах, дугаарлах;

-тэсрэх материал тавьж олгох;

-тэсэлгээний механикжуулсан тоног төхөөрөмж байрлуулах; -цүнх, дайз хадгалах;

-цахилгаан хуваарилах байгууламж ба галаас хамгаалах хэрэгсэл байрлуулах камерууд орно.

772. Газрын доорх агуулахын байршил нь дараахь нөхцөлийг хангасан байна.

а) тэсрэх материалын агуулахын дурын цэгээс босоо ам болон босоо амны орчмын малталт, түүнчлэн агааржуулалтын хаалга хүртэлх зай (байгууламжуудад эвдрэл гарвал далд уурхай болон түүний ихэнх хэсэгт нь өгөгдөх цэвэр агаарын урсгалыг хаах аюултай тул) камерын агуулахын хувьд малталтын дагуу 100 метрээс багагүй;

б) тэсрэх материалын агуулах дахь хамгийн ойрын камераас хүн байнга зорчдог малталт хүртэлх зай камерын агуулахын хувьд 25 метрээс багагүй;

в) агуулахаас газрын гадарга хүртэлх зай камерын агуулахын хувьд 30 метрээс багагүй;

г) тэсрэх материал хадгалах камер байрлуулсан малталт нь үндсэн малталтуудтай бие биетэйгээ тэгш өнцөг үүсгэж уулзсан гурваас цөөнгүй

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага шулуун болон муруй малталтаар холбогдоно.

Агуулахтай холбогдох малталт нь 2 метрээс багагүй урттай, 4 м2-аас багагүй хөндлөн огтлолтой мухар малталтаар төгссөн байна.

д) ачих тоног төхөөрөмж ашиглах тэсрэх материалын агуулахын үндсэн малталтын хэмжээ нь тэдгээрийг 90° эргэх хөдөлгөөн хийх боломжтой байх ба ажлын механизмаа эцсийн хэмжээнд нь сунгасан ачаатай үедээ, түүнчлэн малталтын муруй хэсэгт тоног төхөөрөмжийн хоёр талд 60 см-ээс багагүй зай үлдэж байх өргөнтэй, малталтын таазны гэрэлтүүлэг хүртэл 50 см-ээс багагүй зай үлдэх өндөртэй байна.

е) агуулах нь хүнд зориулсан хоёр гарцтай байна. Метро, туннель болон хайгуулын малталт нэвтрэхэд 1 тн-оос ихгүй багтаамжтай агуулах нэг гарцтай байж болно.

ё) метро, туннель болон хайгуулын малталт нэвтрэхэд тэсрэх материалын агуулахын хамгийн ойрын камераас уурхайн босоо ам, хүн явах зориулалтын болон тэжээлийн үндсэн шугам (ус шүүрүүлэлтийн шугам, агааржуулалтын хоолой, кабель)ууд бүхий малталт хүртэлх зай 15 метрээс багагүй;

з) тэсрэх материалын агуулах төмөр замтай холбоотой бол, уурхайн төмөр замаас агуулахын хэсгийн зам төмрийг цахилгаан дамжихгүйгээр тусгаарласан байна.

Тэсрэх материал хадгалах байрууд болон орцуудын хооронд тэсрэлт дамжихаас хамгаалсан төмөр хаалгатай бол камерыг байрлуулсан малталтыг үндсэн малталттай цөөн малталтаар холбож болно. Эдгээр хаалганы байршил болон бүтцийг зураг төслөөр тодорхойлсон байна.

Тэсрэх материалын агуулахыг төв малталт болон налуу малталт, хүн явах зориулалтын малталтуудын хооронд байрлуулахыг хориглоно.

773. Тэсрэх материалын агуулах байрлуулах малталт үл шатах бэхэлгээтэй байна. Бат бөх чулуулагтай малталтад бэхэлгээгүй байж болно.

774. Агуулахын бүх малталтын агаарыг цагт дөрвөн удаа сэлгэж байх тооцоогоор цэвэр агаарын урсгалаар агааржуулж байна. Агуулахын малталтаас гарч буй агаарын урсгалыг малталтуудын чиглэлд цэвэр агаарын урсгалтай хольж явуулахыг хориглоно.

775. Газрын доорх тэсрэх материалын агуулах нь гал унтраах ердийн эсвэл автомат төхөөрөмжтэй байна. Агуулах бүрийн орцоос 10 метрийн зайд галын шугаманд хаалт тавьж, гал унтраах хошуу байрлуулна. Агуулах руу орох малталтын эхэнд галын хамгаалалтын хаалга байрлуулна.

776. Далд уурхайн агуулах руу орох малталтад ашиглах цахилгаан тоног төхөөрөмж нь хий, тоосны аюултай уурхайд тэсрэлтийн хамгаалалттай, бусад уурхайд ердийн байна. Агуулахын болон түүн рүү орох малталтын гэрэлтүүлгийн кабель нь шатдаггүй бүрээс хамгаалалттай байна.

Гэрэлтүүлгийн шугамын хүчдэл 220В-оос илүүгүй, хэлхээ нь гүйдлийн шүүрлийн хамгаалалттай байна.

Агуулах руу орох малталт болон туслах камеруудыг таазанд, агуулахыг хаалганы дээрх цонхны гадна байрлуулсан гэрэлтүүлгээр гэрэлтүүлнэ.

777. Далд уурхайн агуулахын хамгаалалтын автомат дохиолол нь уурхайн диспетчертэй холбоотой байна.

778. Тоосны дэлбэрэлтийн аюултай нүүрсний болон шатдаг занарын уурхай дахь тэсрэх материалын агуулахын орох малталт, түгээх камеруудын хоёр талд шаталтад идэвхгүй занарын болон усан хөшиг байрлуулна. Эдгээр малталтад хуралдсан тоосыг тогтмол хугацаанд цэвэрлэж байхын зэрэгцээ идэвхгүй занараар занаржуулах арга хэмжээ авч байна.

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага

779. Агуулахын орох хаалга болон тэсрэх материал түгээх камерын дэргэд холбооны хэрэгсэлтэй байна.

780. Далд уурхайн түгээх камерт тэсрэх материал хадгалах, хамгаалахад далд уурхайн агуулахын нэгэн адил шаардлага тавина. Түгээх камерт тэсрэх бодис, өдөөх хэрэгслийн бие биенээсээ 25 см-ээс багагүй зузаантай бетонон буюу тоосгон таславчаар тусгаарлан хадгална. Түгээх камерт тэсэлгээчинд материал тавьж олгох байрыг тоногловсон байна.

781. Түгээх камерыг хүмүүс вагонд суух, буух газар болон уулын цул ачиж буулгах газраас 200 метрээс ойргүй зайд байрлуулна.

1000 кг хүртэл багтаамжтай түгээх камерыг тухайн түвшингийн малталтыг өргөсгөн 25 см-ээс багагүй зузаантай бетонон болон тоосгон ханаар тусгаарлан байгуулж, уурхайн агааржуулалтын шинэ урсгалаар агааржуулна. 1000 кг-аас дээш багтаамжтай түгээх камерыг хүн тогтмол явдаг малталтаас 25 метрээс ойргүй зайтай газарт тусгайлан байршуулж, газрын доорх тэсрэх материалын агуулахад тавих шаардлагын дагуу агааржуулна.

782. Түгээх камер нь шатдаггүй бэхэлгээтэй, байнгын гэрэлтүүлэгтэй байна. Түгээх камер руу орох малталт 5 метрээс багагүй зайд шатдаггүй бэхэлгээтэй байна.

Тэсрэх материал хураах зориулалтын тавиуртай байна. Тэсэлгээний гал өгөх машин, шалгах хэмжих тоног төхөөрөмж, бусад хэрэгслийг хайрцагт хийж хадгална. Үйлдвэрийн сав баглаатай тэсрэх бодисыг өрж хурааж болно.

### **Тэсрэх материалын бүртгэл, тооцоо**

799. Хадгалахаар авчирсан тэсрэх материалыг агуулахад оруулж бүртгэлд авна.

800. Байгууллага нь тэсрэх материалыг агуулахын бүртгэлд авах, гаргах, тэсэлгээнд олгох, буцаахдаа “Тэсрэх материалын агуулахын бүртгэлийн дэвтэр”-ийг энэхүү дүрмийн хавсралт 10-т заасан загварын дагуу заавал хөтөлнө.

801. Тэсрэх материалын агуулахын бүртгэлийн дэвтрийг дугаарлаж үдсэн байхаас гадна байгууллага, санхүүгийн албаны тэмдгээр баталгаажуулсан байна. Агуулахын бүртгэлийн дэвтрийг агуулахын нярав хүлээн авсан, олгосон тэсрэх материалын нэр төрөл тус бүрээр нь, тухай бүр бүртгэл хөтөлнө.

802. Агуулахаас тэсрэх материалыг өөр байгууллагад шилжүүлж буй байгууллагын санхүүгийн алба “Зарлагын баримт” үйлдэж хүлээн авагчид өгөх бөгөөд уг хуудас нь Мэргэжлийн хяналтын байгууллагын “Тэсрэх материал тээвэрлэх хуудас”-ын хамт агуулахаас тэсрэх материал гаргах баримт болно. Агуулахын нярав нь дээрх баримт бичгийг үндэслэн тэсрэх материалыг өөр байгууллагад олгохдоо зарлагын падааныг хоёр хувь үйлдэж нэг хувийг агуулахад үлдээж, хоёр дахь хувийг хүлээн авагчид олгоно. Зарлагын падаанд тэсрэх материалын нэр төрөл, үйлдвэрлэгч, ашиглах хугацаа, сери дугаарыг тэмдэглэсэн дагалдах хуудсыг хавсаргана.

803. Тэсрэх материалыг тухайн байгууллагын нэг агуулахаас нөгөөд шилжүүлэх тохиолдолд байгууллагын тэсрэх материал олгох зөвшөөрлийг үндэслэн нярав зарлагын падаан, дагалдах хуудсын хамт хоёр хувь үйлдэж, нэг хувийг агуулахад үлдээж, хоёр дахь хувийг хүлээж авах агуулахад илгээнэ.

804. Түгээх агуулахад даалгаврын хуудасны дагуу олгосон тэсрэх материалыг агуулахын бүртгэлийн дэвтэрт бүртгэж байна. Тэсэлгээчний даалгаврын хуудсыг энэхүү дүрмийн хавсралт 13-т заасан загварын дагуу бөглөнө.

805. Агуулахаас тэсрэх материал олгох, хүлээж авах баримт бичигт олгосон, хүлээж авсан болон хүргэлт тээвэрлэлтийн ажилтан, тэсэлгээний ажлын удирдагч зэрэг тэсрэх материал хүлээлцэхэд оролцсон ажилтнуудын албан тушаал, нэрийг гаргацтай бичиж, гарын үсгээр баталгаажуулна.

Газрын доорх хэсгийн хадгалах байруудад хүргэсэн тэсрэх материалын хөдөлгөөнийг

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага агуулахын бүртгэлийн дэвтэрт тусгана.

806. Нярав нь тэсэлгээчинд тэсрэх материал тавьж олгохдоо тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл дээрх үйлдвэрлэгчийн тэмдэглэсэн бүтээгдэхүүний марк, хувийн дугаарыг “Тэсрэх материалын агуулахын бүртгэлийн дэвтэр”-т тэмдэглэж үлдээнэ.

807. Нярав нь түгээх агуулахаас тэсэлгээний ажилд зориулан тэсрэх материалыг байгууллагын тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагчийн баталсан “Даалгаврын хуудас”-ыг үндэслэж тавьж олгох ба даалгаврын хуудасны нэг хувийг авч үлдэнэ. Тэсэлгээний ажлын удирдагч даалгаврын хуудсанд гарын үсэг зурна.

Үүнээс гадна даалгаврын хуудсанд хий, тоосны аюултай нүүрсний болон хүдрийн уурхайд тэсэлгээний болон агааржуулалтын албаны удирдлага гарын үсэг зурах ба уурхайн тэсэлгээний ажлын хариуцлагатай удирдагч батална.

808. Тэсэлгээний ажлын дараа тэсэлгээг гүйцэтгэсэн тэсэлгээчин тэсрэх материалын бодит зарцуулалтын хэмжээг даалгаврын хуудсанд тусгаж, тэсэлгээний ажлын удирдагч гарын үсэг зурж баталгаажуулна.

Тэсэлгээчин тэсэлгээний ажил дууссаны дараа үлдсэн тэсрэх материалыг даалгаврын хуудасны хамт өөрийн биеэр тэсрэх материалын агуулах (түгээх камер, хэсгийн хадгалах байр)-нд хүргэж өгнө.

Өмнө нь авсан тэсрэх материалын тооцоогоо хийгээгүй тэсэлгээчинд тэсрэх материал нэмж олгохгүй.

809. Бүртгэлийн дэвтэрт харандаагаар бичих, засвар оруулах, тэмдэглэгээг арилгах зэргийг хориглох ба тоон үзүүлэлтэд аливаа засвар хийхээр бол шинээр өгөгдөл оруулж, засвар нэг бүр дээр тайлбар бичиж тэмдэглэгээ хийсэн хүн гарын үсгээ зурж баталгаажуулна. Байгууллага нь 801-808-д дурдсан орлого, зарлагын бүртгэлийн дэвтрийг 3-аас доошгүй жил хадгалах ёстой.

810. Тэсрэх материалын агуулах дээр тэсрэх материалыг олгоход даалгаврын хуудас, дагалдах бичигт гарын үсэг зурж зөвшөөрөл өгөх эрх бүхий болон тэсрэх материалын бодит зарцуулалтыг нотолж зурсан албан тушаалтны гарын үсэгний хуулбар тус тус хадгалагдаж байх ёстой. Гарын үсэгний хуулбарыг байгууллагын удирдлага баталсан байна. Тэсрэх материалыг олгох баримтанд өөр хүн гарын үсэг зурсан бол олгохыг хориглоно.

811. Тэсрэх материал түгээх камерын бүртгэл нь тэсрэх материалын агуулахын бүртгэлтэй ижил байна.

812. Төмөр замын өртөө болон бусад өөр тээврийн хэсэг дээр ирсэн тэсрэх материалыг хүлээн авахдаа байгууллагын удирдлага нь хүлээн авах ажиллагааг хариуцсан ажилтнаа томилж, хамгаалалтын багийн хамт явуулах үүрэг хүлээнэ.

813. Байгууллага нь тэсрэх материалыг агуулахын бүртгэлд авах, хасах тооцоог агуулахын эрхлэгчээс явуулсан агуулахын бүртгэлийн дэвтрийг үндэслэж хийнэ.

814. Тэсрэх материалын бүртгэл тооцоо, хадгалалт хамгаалалт, бэлэн байдалтай холбоотой агуулахын мэдээлэл үнэн зөв эсэхийг байгууллагын удирдлагын тушаалаар томилогдсон албан тушаалтан сар бүр нягталж шалгана. Баглаа боодол нь гэмтээгүй лац бүрэн сав хайрцаг, уут, чингэлгийг нээж онгойлгохгүй байж болно.

815. Нээж онгойлгосон хайрцагтай цахилгаан тэслүүр, ердийн тэслүүр, пиротехникийн реле болон бусад тэсэлгээний хэрэгслийн тоо хэмжээг агуулахын үүдний өрөө, эсвэл тусгай камерт, эсвэл агуулахын гадна тоолж шалгана. Ингэхдээ тэдгээрийг тогтоосон шаардлага хангасан ширээн дээр тавьж тоолно.

816. Шалгалтын үр дүнд илэрсэн тэсрэх материалын илүүдэл, дуталтын талаар тухайн байгууллагын удирдлага болон мэргэжлийн хяналтын байгууллага, орон нутгийн цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэнэ.

## **ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН АГУУЛАХ, ҮЙЛДВЭРИЙН ХАМГААЛАЛТЫН ЖУРАМ**

1. Газрын гадарга дээрх тэсрэх материалын агуулах, үйлдвэр, тэсрэх материал хадгалах, түгээх зориулалт бүхий талбай нь гэрээт харуул хамгаалалтад, далд уурхай дахь богино хугацаагаар тэсрэх материал хадгалах, түгээх зориулалт бүхий байр нь тэсэлгээний ажил гүйцэтгэгчийн харуул хамгаалалтад байна.
2. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага дараахь үүрэгтэй:
  - хамгаалалтын байгууллагатай гэрээ байгуулах;
  - тэсрэх материалын агуулахын харуул хамгаалалтыг зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, холбоо, дохиоллын систем, харуулын байр, цамхгийн байгууламжаар хангах;
  - байгууллагынхаа холбогдох ажилтны хаягийн бүртгэл, хамгаалалтад байгаа объектод нэвтрэх эрх бүхий албан тушаалтны болон тэсрэх материалтай харьцах, тэдгээрийг хариуцаж байгаа албан тушаалтны нэрийг харуул хамгаалалтын албанд өгөх;
  - харуул хамгаалалтын албаны гүйцэтгэх үүргийг танилцуулах, заавар зөвлөмжөөр хангах, зохих баталгаа гаргуулах, өөрийн байгууллагад гарсан өөрчлөлтийг тухай бүрт нь танилцуулж байх;
  - объектын хамгаалалтын талаар төрийн хяналтын байгууллагын болон харуул хамгаалалтын албанаас тавьсан шаардлагыг биелүүлэх;
  - хууль, тогтоомж, гэрээнд заасан бусад үүрэг.
3. Тэсрэх материалын агуулахын харуул хамгаалалтын ажилтан дараахь үүрэгтэй:
  - агуулахад нэвтрэх эрхийн үнэмлэхийг шалгах, тэсрэх материал оруулах болон гаргахад хяналт тавих;
  - тэсрэх материалыг зөвшөөрөлгүй нэвтрүүлэх оролдлогыг таслан зогоох, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
  - агуулах болон түүний ойр орчинд байгалийн аюул, гамшиг (үер, гал түймэр г.м) тохиолдох үед үйлчлүүлэгч болон онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад нэн яаралтай мэдэгдэх;
  - хамгаалж байгаа объектын бүрэн бүтэн байдал, лац ломбыг шалган хүлээн авах, хүлээлгэн өгөх, хэрэв объектын бүрэн бүтэн байдал алдагдсан, лац ломбо хөдөлсөн байвал энэ тухай үйлчлүүлэгчид нэн даруй мэдэгдэх;
  - агуулахад тэсрэх материал оруулж, гаргахыг гэрээнд заасан зөвшөөрөл, нөхцөлөөр гүйцэтгүүлж, энэ тухай тэмдэглэл хөтлөн агуулахын нярав, хүлээн авагчаар гарын үсэг зуруулж баталгаажуулах;
  - хууль, тогтоомж, гэрээнд заасан бусад үүрэг.
4. Харуул хамгаалалтын албаны хэрэгцээт галт зэвсэг, тусгай хэрэгсэл, түүнийг хэрэглэх асуудлыг “Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль”- ийн дагуу зохицуулна.
5. Тэсрэх материалын агуулахын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага агуулахад хяналтыг тогтоож дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ.
  - агуулах, түүний объектод нэвтрэх дотоод журмыг тогтоох;
  - тэсрэх материалыг агуулахад оруулах, гаргах журмыг тогтоох.
6. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын тушаалаар баталсан агуулах, түүний объектод нэвтрэх дотоод журам, тэсрэх материалыг оруулах, гаргах журмыг агуулахын ажилтан, объектыг хамгаалж байгаа бүрэлдэхүүнд танилцуулж гарын



Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага авлага болгон өгсөн байна.

7. Тэсрэх материалын агуулахын хадгалалт, хамгаалалтын байдал, энэ талаарх хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлтийг улсын мэргэжлийн хяналтын болон цагдаа, тагнуул, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага тус тусын чиг үүргийн дагуу шалгана.
8. Улсын мэргэжлийн хяналтын болон цагдаа, тагнуул, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын эрх бүхий ажилтан албан газрын үнэмлэх, байгууллагын удирдлагаас баталсан ажлын удирдамжаа үзүүлж агуулах, түүний объектод нэвтрэх эрх эдэлнэ.

Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах ажилтны гарын авлага